

ХҮРТЭЭМЖТЭЙ САНХҮҮ

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол







2020 · 03 сар | Дугаар 16

ГАРЧИГ

- 2–3** Хадгаламж, зээлийн хоршооны тогтворжилтын сангийн үйл ажиллагаа
- 3–4** Зохицуулалтын мэдээ
- 4–7** Байр суурь
- 7–8** Тайлбар ба зөвлөмж
- 8–9** Финтек ба регтек
- 10–13** Хөрөнгийн зах зээлийн тодорхойгүй байдалд “miles-ezell болон modigliani-miller”-ийн засварлалтыг ашиглах нь
- 14** “Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК
- 14** Өргөн дуран
- 14** Санхүүгийн боловсрол
- 17–19** Компанийн засаглал, комплайнс
- 19–21** Зах зээлийн мэдээ
- 22–23** Олон улсын зах зээлийн мэдээ
- 24** Олон улсын хөрөнгийн зах зээлийн индекс

Хүртээмжтэй санхүү

Санхүүгийн зохицуулах хорооны товхимол

-  Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160
-  +976-51-264444
-  press@frc.mn
-  www.frc.mn
-  Санхүүгийн зохицуулах хороо
-  @FRC_of_Mongolia

Зах зээлийн судалгаа хөгжлийн газар

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОНО



“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар СЗХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга Н.Оюунчимэг санхүүгийн зах зээлийн судалгаа, хөгжлийн нэгдсэн бодлогын талаар ярилцлага өглөө.

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ удаагийн ярилцлагаа ойрын хугацаанд дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаар ямар зураглал харагдаж байна вэ? Мөн олон улсын санхүүгийн зах зээлд гарч байгаа өөрчлөлтүүд манайд хэрхэн нэвтэрч байна? гэсэн асуултаас эхлэе.

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн уншигч Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Олон улсын валютын сангийн тооцоолсноор дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд 3.3 орчим хувьд хүрэхээр хүлээгдэж байсан хэдий ч 1 дүгээр сараас эхлэн дэлхий нийтээр дэгдэж буй шинэ төрлийн

коронавирусын өвчлөлийн нөлөөгөөр дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал үүсээд байна. 2019 онд хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд 2008 оны санхүүгийн хямралаас хойших хамгийн өндөр түвшиндээ хүрсэн хэдий ч дэлхийн эдийн засагт үүссэн тодорхой бус байдлын нөлөөгөөр өнгөрөгч саруудад уналт, савлагааг үзүүлээд байна. Өөрөөр хэлбэл, оны эхэнд тархаж буй корона вирусийн нөлөөлөл дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдал үүсгэж судлаач, шинжээчид эдийн засаг, санхүүгийн зах зээлийн талаарх таамаглалаа эргэж харахад хүрээд байгаа юм.

Үргэлжлэл 5-р нүүрт >>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛБАНК, САНГИЙН ЯАМ, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ ХАМТРАН ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Хөтөлбөрийн үндэслэл

Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй хэвээр байна.

Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл төрөлжин олширсоор байна. Манай улсад иргэн, өрх гэрийн түвшинд санхүүгийн суурь мэдлэг хангалттай бус байгаагаас санхүүгийн буруу шийдвэр гаргаж эрсдэлд орох, энэ нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байгаа нь энэхүү хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

Үргэлжлэл 16-р нүүрт >>

Санхүүгийн зохицуулах хорооны

АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС

Цогц мөн чанар: Хүнлэг, үнэнч, шударга, итгэлтэй, өндөр ёс суртахуунтай байх нь;

Хариуцлагатай байх: Ажил үүргээ гүнээ ухамсарлаж, чин эрмэлзэлтэй, ажлын цагаа ажилдаа бүрэн зориулдаг, хичээнгүй нямбай, түргэн шуурхай, хувийн зохион байгуулалт сайн байх нь;

Мэргэжлийн байх: Өндөр мэдлэг, үр чадвар эзэмшсэн, өрсөлдөх чадвартай, ёс зүйтэй, зөв шийдэл гаргах чадвартай байх нь;

Бие даасан байх: Хувийн ашиг сонирхлоос ангид, хөндлөнгийн нөлөөгүй, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь;

Манлайлал, санаачлагатай байх: Шинийг эрэлхийлэгч, сайжруулан хөгжүүлэгч, манлайлагч, бүтээлч тэмүүлэлтэй байх нь;

Багаар ажиллах: Нэг зорилгын төлөө мэдлэг мэдээллээ хуваалцах, хамт олноо сонсох, итгэл хүндэтгэлтэй хандах, дэмжин туслах, жигд оролцоотойгоор үр өгөөжтэй хамтран ажиллах чадвартай байх нь

Бидний үнэт зүйлс юм.



БОДЛОГЫН НИЙТЛЭЛ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


Хадгаламж, зээлийн хоршоо /ХЗХ/-ны зах зээлийн найдвартай байдлыг хангах, хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд дэлхийн улс орнууд хадгаламж, зээлийн хоршооны хамгаалалтын 2-3 давхарга бүхий тогтолцоог бий болгон ирсэн.

Хамгаалалтын нэгдүгээр давхарга нь хадгаламж, зээлийн хоршоодын цэвэр орлогоос байгуулдаг нөөцийн сан юм. Харин хоёрдугаар давхарга нь үйл ажиллагаа нь түр хугацаанд хүндрэлд орсон, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь алдагдсан хоршоодод мэргэжил арга зүйн болон санхүүгийн туслалцааг үзүүлж, үйл ажиллагааг нь сэргээхэд чиглэдэг тогтворжилтын сан

бөгөөд тус сан нь хадгаламж, зээлийн хоршооны зах зээлийн дэд бүтцийн чухал хэсэг юм. Түүнчлэн хамгаалалтын гуравдугаар давхарга болох хадгаламжийн даатгал нь төлбөрийн чадвараа бүрэн алдсан хадгаламж, зээлийн хоршооны даатгагдсан хадгаламжийг хадгаламж эзэмшигчдэд нөхөн олгодог онцлогтой.

Улс орнуудын хувьд тогтворжилтын санг ихэвчлэн хадгаламж, зээлийн хоршоодын дундын санхүүгийн байгууллагын дэргэд байгуулдаг ба энэхүү байгууллага нь тухайн орны хууль эрх зүйн зохицуулалтаас хамаараад өөр өөр статус, нэршилтэй /the league, central finance facility, credit unions association, central credit union/ байна.

Тогтворжилтын сангийн ерөнхий бүтэц



ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН ТОГТОЛЦОО

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс: Германы Хоршооллын банкны холбоо /BVR/ нь Төрийн бус байгууллагын тухай хуулиар байгуулагдсан ба гишүүдээ чиглэсэн санхүүгийн үйл ажиллагаа нь банкны хуулиар зохицуулагддаг. Хоршооллын банкны холбоо нь тогтворжилтын болон хадгаламж хамгаалалтын үйлчилгээг хамтад нь үзүүлдэг ба институцийн хамгаалалтын схем гэж нэрлэгддэг. Институцийн хамгаалалтын бүтэц нь тус улсын банкны хууль болон Хадгаламжийн даатгалын хуулийн шаардлагыг хэрэгжүүлж ажиллана. Германы Хоршооллын банкны холбооны хамгаалалтын бүтцийн үйл ажиллагааны хяналтыг Германы Санхүүгийн хяналт шалгалтын байгууллага /BaFIN/ хэрэгжүүлнэ.

Бүгд Найрамдах Ирланд Улс: Тогтворжилтын санг Ирландын хадгаламж, зээлийн хоршоодын лиг /the league/ хэрэгжүүлдэг ба Хадгаламжийн хамгаалалтын схем /Savings Protection Scheme/ нэртэй. Энэхүү

схем нь хадгаламжийн хамгаалалт гэсэн нэртэй боловч үзүүлж буй үйлчилгээ нь тогтворжилтын үйлчилгээ юм. Анх 1960 онд сайн дурын үндсэн дээр байгуулагдсан ба 1980 онд хөрөнгө оруулалтын сан болж хуульчлагдсан бөгөөд үйл ажиллагаагаа төрийн хадгаламжийн даатгалын тогтолцоотой уялдуулан явуулдаг.

Бүгд Найрамдах Солонгос Улс: Солонгос Улсын Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний нэгдсэн холбоо нь хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн дагуу байгуулагдаж, гишүүдээ дэмжих, хөгжлийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх үйл ажиллагааг эрхэлдэг. Холбоо нь тогтворжилтын болон хадгаламжийн даатгалын үйлчилгээг үзүүлдэг ба бүтэц нь гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын бүтэцтэй ижил, Санхүүгийн үйлчилгээний хорооны хяналт дор ажиллана. Гишүүн хадгаламж, зээлийн хоршоод нь холбоондоо сар бүр тайлангаа хүргүүлдэг ба бүх хоршоод уг холбооны гишүүн байх ёстой.

Америкийн Нэгдсэн Улс: Тус улсын хувьд Үндэсний хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /NCUA/ нь хадгаламж, зээлийн хоршооны түр тогтворжуулах сан /The Temporary Corporate Credit Union Stabilization Fund, /TCCUSF/-гийн удирдлагыг хэрэгжүүлдэг ба Үндэсний хадгаламж, зээлийн хоршоодын хамтын даатгалын сан /National Credit Union Share Insurance Fund, /NCUSIF/-гаас тусдаа бүтэцтэй байсан. Тус холбооны захирлуудын зөвлөлөөс 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр дээрх 2 санг нэгтгэх шийдвэр гаргасан ба нэгдэх үйл явц явагдаж байна.

Польш Улс: Польш Улсад хадгаламж, зээлийн хоршоо нь анх ЗХУ-ын задралын дараа буюу 1992 онд үүсгэн байгуулагдсан. Тус улсад одоогоор 61 ХЗХ, 1,800 салбартайгаар үйл ажиллагаа явуулдаг ба 2 сая гаруй хүнийг хамарсан гишүүнчлэлтэй /нийт хүн амын 15 хувь/, банкны салбарын 1.4 хувийг эзэлдэг. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль 1995 онд батлагдсан.

Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /National Association of Credit unions NASCU=SKOK/ нь өөрийгөө зохицуулах байгууллагын статустай ба тогтворжилтын сангийн менежментийг хийдэг. Тус холбооны дэргэд тогтворжилтын сангийн зөвлөл /Stabilization fund committee/ ажилладаг ба холбооны удирдах зөвлөлөөс хараат бус байдлаар шийдвэр гаргаж, сангаас тогтворжилтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг байна.

Тогтворжилтын сангийн нийт хөрөнгө нь хадгаламж, зээлийн хоршооны салбарын нийт активын 1 хувиас багагүй байх ба хадгаламж, зээлийн хоршооны зүгээс жил бүр орлогын 0.4 хувийг тогтворжилтын санд төвлөрүүлэх шаардлага тавьдаг. Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо банкны хадгаламж, засгийн газрын бонд, богино хугацаат өрийн бичиг, хөрөнгө оруулалтын сангуудад тогтворжилтын сангийн илүүдэл хөрөнгийг байршуулж орлого олдог.

Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо нь 2 шатлалтай хамгаалалтын системийг хэрэгжүүлдэг бөгөөд тэдгээр нь тогтворжилтын сан болон хадгаламжийн даатгалын сангийн менежмент юм. Мөн тус холбоо нь бие даасан дундын төлбөр тооцооны төв /Settlement services, payment cards and ATM cards/-ийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Хадгаламжийн даатгалын сангаас 50,000 евро хүртэлх хэмжээний

хадгаламжийг даатгалд хамруулдаг.

Литва Улс: Литва Улс 2 түвшний хадгаламж, зээлийн хоршоотой ба тус тусын хуулиар зохицуулагддаг. Тус улс 1995 онд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталж, 1996 онд хамгийн анхны хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагдсан байна. Харин 2000 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Төв хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг баталж, 2002 онд Төв ХЗХ-г үүсгэн байгуулж, дундын санхүүгийн байгууллагын үүргийг гүйцэтгэж дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар түр алдагдсан, санхүүгийн хүндрэлд орсон хоршоодод туслалцаа үзүүлэх зорилгоор Тогтворжилтын сан /Stabilization Fund/ байгуулж удирдах;
2. Банкны салбараас тусдаа бие даасан төлбөр тооцооны системийг сайжруулахын тулд клирингийн төвийн үүргийг гүйцэтгэх;

3. Гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын найдвартай байдал, учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
4. Гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод зээлийн шугам нээх, хадгаламж авах болон бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэх.

Литва Улс нь хадгаламж эзэмшигчдийн хөрөнгийг хамгаалахын тулд хамгаалалтын давхарга бүхий тогтолцоог бий болгосон. Тогтворжилтын сан байгуулж, удирдах эрхийг Төв хадгаламж, зээлийн хоршоо хэрэгжүүлж, харин хадгаламж хамгаалалтын сангийн чиг үүргийг Төв банкны зохицуулалтад байх "Хадгаламж болон хөрөнгө оруулалтын даатгал" нэртэй Төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлдэг байна.

Литва улсын хадгаламж, зээлийн хоршооны салбарын дэд бүтэц дараах байдалтай байна.

Литва улсын ХЗХ-ны системийн бүтэц



Эх сурвалж: Литва улсын төв банк

Монгол Улс: Манай улсын хувьд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд тогтворжилтын санг Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоо /МХЗХҮХ/ байгуулж, зөвхөн түүний гишүүд тогтворжилтын үйлчилгээнд хамрагдахаар заасан. МХЗХҮХ нь төрийн бус байгууллагын статустай. Хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн бус байгууллагын тухай хуулиар аливаа ТББ-д сайн дурын гишүүнчлэлтэй байхаар заасан тул холбооноос үзүүлэх тогтворжилтын санд бүх хадгаламж, зээлийн хоршоо заавал хамрагдах албагүй, мөн холбоо нь Хорооны зохицуулалттай этгээд биш тул тогтворжилтын сангийн үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих, хариуцлага тооцох эрх зүйн үндэс байхгүй зэрэг асуудлууд тулгараад байна. Иймд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулж, дундын санхүүгийн байгууллагыг төрийн бус

байгууллагын тухай хуулиар бус салбарын хуулиар зохицуулахаар тусгайлсан бүлэг оруулах, дундын санхүүгийн байгууллагын нэршил, статусыг тусгай зөвшөөрөлтэй зохицуулалттай этгээд байхаар зааж өгөх, дундын санхүүгийн байгууллагад тогтворжилтын сан үүсгэн байгуулах, удирдах эрх хэмжээг өгөх, бүх хадгаламж, зээлийн хоршоодыг дундын санхүүгийн байгууллага болон тогтворжилтын санд заавал гишүүнчлэлтэй байлган дундын санхүүгийн байгууллагын дүрэмд тогтворжилтын санг удирдахад шаардагдах зохицуулалтыг тусгах, Хороо нь дундын санхүүгийн байгууллага, тогтворжилтын сангийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих эрх, үүрэгтэй байхаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

ЗОХИЦУУЛАЛТЫН МЭДЭЭ

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДООС ОЛГОСОН ЗЭЭЛИЙН АНГИЛЛЫН ЖУРАМД ТҮР ХУГАЦААНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛЛАА

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэ төрлийн корона вирус /Covid-19/-ийн улмаас дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт эрсдэлтэй нөхцөл байдал үүсэж эхлээд байгаа энэ үед санхүүгийн салбарт учирч буй эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах, зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөх хуваарьт заасан хугацааг хойшлуулан зээлдэгчдийг зээлийн дарамтаас чөлөөлөх зэрэг зээлийн зөөлөн бодлого авч хэрэгжүүлж эхлээд байна.

Дээрх нөхцөл байдалтай уялдуулан 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршооноос олгосон зээлийн ангиллын хугацаанд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн дэмжлээ.

Энэ хүрээнд санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, харилцагч, зээлдэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125, 145/124 дүгээр хамтарсан тушаалаар тус тус баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-тай холбоотой дараах шийдвэрүүдийг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахаар шийдвэрлээд байна. Үүнд:

1. Зээлийн гэрээний хугацааг 2 болон түүнээс дээш удаа сунгасан бол зээлдэгчийн зээлийн ангилал өөрчлөгдөж хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлд шилжиж “Зээлийн мэдээллийн сан”-д бүртгэгдэж байсан зохицуулалтын үйлчлэлийг дээрх хугацаанд зогсоох;
2. Зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн эргэн төлөлт нь хугацаандаа хийгдэж байгаа бол хэвийн зээлд тооцохоор байсныг 120 хоногоор хугацаа хэтэрсэн бол хэвийн зээлд тооцохоор, хугацаа хэтэрсэн зээлийн ангилал 1-90 хүртэл хоног байсныг 121-180 хоног, чанаргүй зээлийн ангилалд 181 хоногоос дээш хугацаанд хугацаа хэтэрсэн тохиолдолд бүртгэж байхаар тус тус зохицуулалт хийлээ.

Энэхүү шийдвэр нь зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учирч буй зээлдэгчид зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, “Зээлийн мэдээллийн сан”-д ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлж байна.

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуульд зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулж байхаар зохицуулсан.

Хэрэв дээр дурдсан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх дуусгавар болдог ба бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус болох үр дагавар үүсэх юм.

Гэвч энэ цаг үед дэлхийн хэмжээнд “COVID-19” шинэ коронавирусын халдвар дэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолыг баталж шинэ корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн, улмаар энэхүү хугацааг 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл сунгаад байна.

Энэ хүрээнд Улсын онцгой комиссын даргын 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн 13-т зааснаар олон нийтийг хамарсан уулзалт, сургалт, семинар, ёслол хүндэтгэл, урлаг, спортын арга хэмжээг зогсоосон.

Онцгой нөхцөл байдал үүссэн тул “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй хувьцаат компаниуд нь хуульд заасан хугацаанд ээлжит хурлаа хувьцаа эзэмшигчдийг биеэр оролцуулан нэг дор зарлан хуралдуулах боломжгүй болоод байна.

Иймд үүсээд буй нөхцөл байдалд нийцүүлэн хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, онлайн орчинд зайны технологийг ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувьцаа эзэмшигчдийн эрх, оролцоог хангуулах зэргээр ээлжит хурлыг өөрийн онцлог тохирсон боломжтой хэлбэрээр зохион байгуулах нь зүйтэй.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО “ОНЛАЙН” ХУРАЛДЛАА

Шинэ коронавирусын халдварын дэгдэлттэй холбоотой Улсын онцгой комиссын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмжийн дагуу Хорооны 2020 оны ээлжит 5 дугаар хуралдааныг “онлайн видео хурал” хэлбэрээр зохион байгуулж, 19 асуудлыг хэлэлцэн



шийдвэрлэв.

Хуралдаанаар “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталж, журмын хүрээнд үл хөдлөх эд хөрөнгө зуучлагчид Хорооноос тусгай зөвшөөрөл авснаар энэ үйл ажиллагааг эрхлэхээр болов.

“ҮЦТХТ” ХХК-д үнэт цаасны зах зээлд төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Ард капитал групп ҮЦК” ХХК-д номинал дансаар дамжуулан харилцагчид мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгож, “Аккаунт траст аудит” ХХК-г үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйл ажиллагаа үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэлээ.

“Даатгалын зах зээлийн ёс зүйн журам”-ыг шинэчлэн баталж, зарим даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтан, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнийг шинэчлэн бүртгэв.

Хадгаламж, зээлийн хоршоо, ББСБ-уудын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг сунгах, тусгай зөвшөөрөл нэмж олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг асуудлуудыг мөн хэлэлцэн шийдвэрлэлээ.

ДААТГАЛЫН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДАВ

Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2020 оны 29 тоот тушаалаар “Даатгалын бодлогын зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг төрийн болон төрийн бус байгууллага, даатгалын салбарын мэргэжлийн холбоод, их, дээд сургуулийн багш, судлаачдын төлөөллийг оролцуулан шинэчлэн баталсан.

Даатгалын бодлогын зөвлөл нь даатгалын салбарын ойрын болон



дунд хугацааны хөгжлийн бодлогыг тодорхойлоход оролцох, бодлогын баримт бичгийн хэлэлцүүлэг зохион байгуулах болон бусад хэлбэрээр олон нийт, төрийн бус байгууллага, хорооны зохицуулалттай аж ахуйн нэгжүүдээс санал авах, санхүүгийн зах зээлийн судалгаа хийх, судалгаа хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэсэн зөвлөмж гаргах, санхүүгийн суурь мэдлэгийг олон нийтэд түгээх үндсэн чиг үүрэгтэй ажиллах юм.

Зөвлөлийн энэ оны эхний хурал 2 дугаар сарын 21-ний өдөр зохиогдож, хурлыг зөвлөлийн дарга СЗХ-ны гишүүн Л.Энхтайван удирдан явууллаа. Хурлаар 2020 онд даатгалын салбарын бодлого, зохицуулалтын чиглэлээр хэрэгжүүлэх ажлын талаар зөвлөлийн гишүүдийн танилцуулгыг сонсож, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ.

БАЙР СУУРЬ



» Эхлэл 1-р нүүрт

“Хүртээмжтэй санхүү” сэтгүүлийн энэ удаагийн байр суурь булангаар СЗХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын дарга **Н.ОЮУНЧИМЭГ** санхүүгийн зах зээлийн судалгаа, хөгжлийн нэгдсэн бодлогын талаар ярилцлага өглөө.

БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОНО

Covid-19-ийн нөлөөлөл, тодорхой бус байдлыг хасаад тооцвол сүүлийн жилүүдэд дэлхийн эдийн засаг, санхүүгийн салбарт хамгийн их яригдаж буй ирээдүйд томоохон өөрчлөлтийг бий болгох 2 төрлийн дэвшил бий болоод байна. Эхнийх нь технологийн өөрчлөлт бол дараагийнх нь улс орон бүрийн бодлого гаргагчдын чухал зорилт болсон Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал юм. Байгаль орчинд ээлтэй, ногоон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэгш бус байдал, ядуурлыг бууруулахад чиглэсэн бичил санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ болон финтекийн нэвтрэлт нь дэлхийн санхүүгийн салбарт хурдтайгаар нэвтэрч эдийн засаг, нийгэмд томоохон өөрчлөлтийг бий

болгожээ.

Санхүүгийн салбарт гарч буй инновациуд уламжлалт банкны загварыг халан олон тулгуурт төвлөрсөн бус санхүүгийн салбарыг үүсгэж байгаагаас гадна санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хамрах хүрээ улам бүр даяаршиж дэлхий нийтээрээ холбогдож байна. Энэхүү өөрчлөлтүүд ч манай улсын санхүүгийн зах зээлд нэвтрээд байна. Тухайлбал, 2019 оны жилийн эцсийн байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын харилцагчдын тоо 1.8 дахин өсөж 2.9 саяд хүрсэн нь санхүүгийн үйлчилгээнд дэвшилтэт технологи /финтек/-ийг ашиглаж, уламжлалт зээлийн үйлчилгээг

хялбар, түргэн, шуурхай, барьцаагүй, онлайн зээлийн үйлчилгээ нэвтрүүлсэнтэй холбоотой юм. Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн тоо 419.9 мянгад хүрсний 63.2 хувь буюу 265.3 мянга нь финтекийн зээлийн үйлчилгээ авсан зээлдэгчид байна.

Өрсөлдөх чадвартай, тогтвортой санхүүгийн системийг бий болгохын тулд бид хэрхэн ажиллаж, юунд анхаарах хэрэгтэй байна вэ?

Олон тулгуурт санхүүгийн зах зээлийг бүрдүүлэх нь тогтвортой санхүүгийн системийн зайлшгүй шаардлага байдаг. Дэлхий нийтэд эрчимтэй яригдаж буй ногоон санхүүжилт, бичил санхүүгийн зах зээл, финтек нь ихэвчлэн банкнаас бусад санхүүгийн салбарт яригдаж буй тул энэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай нэвтрүүлэх, эдийн засаг, санхүүгийн салбарын өрсөлдөх чадвараа сайжруулахад банкнаас бусад санхүүгийн салбарын үүрэг ихээхэн чухал юм.

Сүүлийн 5 жилийн хугацаанд банкнаас бусад санхүүгийн зах зээл /хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, бичил санхүүгийн салбар/ 2.3 дахин өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд цаашид өсөлтийг хадгалан, зах зээлээ чадавхжуулахад төрийн зүгээс бодлого, шийдвэрээ тууштай баримталж, үр дүнтэй хэрэгжүүлэх нь гол асуудал билээ.

Технологийн хурдацтай өөрчлөлт, дэлхий нийтэд өрнөж буй санхүүгийн зах зээлийн интегралчлалыг даган санхүүгийн зах зээлд баримтлах бодлого, зохицуулалтад мөн өөрчлөлт орж байна. Мобайл банкны үйлчилгээ, зөвлөх үйлчилгээний робот, арилжааны платформ, цахим сүлжээгээр холбогдсон зээл зэрэг олон дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээ санхүүгийн салбарт гарч буй хэдий ч зохицуулагч байгууллагын зүгээс бид эдгээр технологийн өөрчлөлтийг зөвхөн технологийн дэвшил талаас нь харахын зэрэгцээ хэрэглэгчдийн эрх ашиг, нийгмийн сайн сайхан байдлыг мөн харгалзан үзэх шаардлагатай.

Таны харьяалагдаж буй Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын үндсэн чиг үүрэг юу вэ? Санхүүгийн зах зээлд аль талаас нь ямар үүргийг гүйцэтгэж байгаа вэ?

Өөр хоорондоо санхүүгийн салбар улам бүр уялдаа холбоотой болж, шинэ төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ ихээр гарч буй өнөө үед санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалахын тулд судалгаа, шинжилгээнд суурилсан хөгжлийн нэгдсэн бодлогоор хангах хэрэгцээ

шаардлага үүсэж байгаа юм. Тийм ч учраас бид хөрөнгийн, даатгалын зах зээл болон бичил санхүүгийн салбарыг хөгжүүлэхэд бүтээгдэхүүн, үйлчилгээний хоорондын уялдаа холбоог хангаж, тэдгээрийн бодлогыг нэгтгэх зорилгыг тавин ажиллаж байна. Энэ хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, ил тод, шударга, хүртээмжтэй санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, банкнаас бусад санхүүгийн зах зээлийг хөгжлийн нэгдсэн бодлогоор хангах зорилтын хүрээнд олон улсын санхүүгийн зах зээлийн болон дотоодын макро эдийн засаг, банк, бичил санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн талаарх нэгдсэн мэдээллийг цуглуулж, боловсруулан судалгаа, дүгнэлт хийж, зах зээлийн бодлого, зохицуулалтыг нэгтгэн, хоорондын уялдаа холбоог хангах, хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Санхүүгийн салбарыг нэгдсэн бодлогоор хангах томоохон ажилд танай газар өндөр оролцоотой байна гэж ойлголоо. Тэгвэл одоогоор танай газар дээр нэгдсэн бодлогын хүрээнд ямар ажлууд хийгдэж байна вэ?

2020 онд эхлүүлэх шаардлагатай гол арга хэмжээний нэг бол санхүүгийн зах зээлийн системийн эрсдэлийн үнэлгээг хийх юм. Учир нь 2008 оны дэлхийн санхүүгийн зах зээлийн хямралыг үүсгэгч хүчин зүйл нь системийн эрсдэл байсан ба үүнийг удирдах бодлогын арга хэрэгсэл нь макро зохистой бодлого. Уг хямралаас хойш 10 гаруй жил өнгөрөхөд макро зохистой бодлогыг хөгжсөн болон хөгжиж буй орнууд хэрэгжүүлж эхлээд өдгөө үр дүнгээ үнэлэх гэж байна. Харин манайх шиг санхүүгийн зах зээл нь хөгжлийн шат руугаа орж эхэлж буй улс оронд хэрхэн системийн эрсдэлийг үнэлж, макро зохистой бодлогыг нэвтрүүлэх нь чухлаар тавигдах болсон. Иймээс 2020 онд банкнаас бусад санхүүгийн зах зээлийн системийн эрсдэлийг үнэлэх аргачлалыг нэвтрүүлж, үнэлгээ хийсэн байх зорилтыг тавин ажиллаж байна.

Мөн өмнө дурдсанчлан энэ онд дэлхий нийтийг хамарсан шинэ коронавирусын халдвар тохион эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхой бус байдлыг үүсгэж байна. Үүнтэй холбоотойгоор халдварт өвчний нөлөө эдийн засгаар дамжин банкнаас бусад

санхүүгийн зах зээлд үүсгэж болох хямралын талаар судалгаа хийж хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулсан. Цаашид манай улсад байгалийн давагдашгүй хүчин зүйл, онцгой нөхцөл байдал тохиолдох, эдийн засаг, санхүүгийн хямрал нүүрлэх үед зайлшгүй урьдчилан тооцсон бэлэн байдлын стратегийг боловсруулан батлуулсан байх шаардлага тулгарч байгаа тул энэ ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, зорилт, арга хэмжээний “Санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгох” зорилгын хүрээнд “Санхүүгийн хүртээмжийг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Санхүүгийн хүртээмж нь ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлт хөгжлийг дэмжих, санхүүгийн салбарын зорилтуудыг уялдаа холбоотойгоор хөгжүүлэх зэрэг чухал нөлөөтэй бөгөөд хүртээмжийг нэмэгдүүлснээр аж ахуйн нэгжүүдийн бүтээмжийг дээшлүүлэх, хөдөөгийн иргэд, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, мөн ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэй юм. Санхүүгийн хүртээмжийг сайжруулахад боловсрол, нийгмийн асуудал эрхэлсэн төрийн байгууллага болон хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллага зэрэг санхүүгийн болон санхүүгийн бус оролцогч талуудын хоорондох уялдаа холбоотой зохицуулалтыг авч үзэх нь чухал юм.

Иймээс бид 2020 онд “Санхүүгийн хүртээмжийн үндэсний стратеги”-ийг боловсруулж, холбогдох талуудаас санал авах, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралд танилцуулах, батлуулахаар бэлтгэж байна.

Та газрынхаа чиг үүрэгт нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх талаар дурдсан. Нэгдсэн бодлого болон мэдээллийн нэгдсэн сан хоёр хоорондоо хэрхэн уялдах вэ?

СЗХ нь судалгаанд суурилсан бодлого, зохицуулалтын шийдвэр гарган ажилладаг учраас суурь үзүүлэлт болох тоон мэдээллийн үнэн зөв, дэлгэрэнгүй, нарийвчилсан байдал маш чухал байдаг. Мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийн хувьд зохицуулалттай этгээдүүдийн санхүүгийн тайлан болон бусад

мэдээг сар болон улирлын давтамжтайгаар ФинА санхүүгийн програмд хүлээн авч, боловсруулалт хийн зайны хяналт шалгалтыг хэрэгжүүлж, судалгаа шинжилгээ хийж, бодлого, зохицуулалтын шийдлүүдийг боловсруулдаг. Иймээс манай газраас зах

зээлийн холбогдолтой тоон мэдээллийг нэгдсэн нэг эх үүсвэрээс хүргэх мэдээллийн нэгдсэн санг бий болгож хөгжүүлэх зорилгоор мэдээллийн сангийн агуулгыг төлөвлөх, эх сурвалжуудаас шаардлагатай мэдээллийг цуглуулах, хамрах хүрээг

нэмэгдүүлэх, хадгалах, боловсруулахад чиглэсэн зохицуулалтыг бий болгох зорилт тавьж ажиллана.

Санхүүгийн зах зээлийн хөгжил, бодлогын талаар ярилцлага өгсөн танд баярлалаа. Танд болон танай газрын хамт олонд ажлын амжилт хүсье.

ТАЙЛБАР БА ЗӨВЛӨМЖ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР БАНКНААС БУСАД МЭДЭЭЛЭХ ҮҮРЭГТЭЙ ЭТГЭЭДЭД ЗАЙНЫ БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

“Мөнгө угаах гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд тодорхойлсон байдаг.



Мөнгө угаах гэсэн нэр томъёо бий болоод удаагүй байгаа хэдий ч мөнгө угаах гэмт хэрэг шинэ биш бөгөөд манай эриний өмнөх 2000 жилийн өмнө татвараас зайлсхийж өөрийн орлогоо удирдагчдаасаа нуун өөр газарт шилжүүлж, өөрийн улсаас гадагш хөрөнгө оруулж, эсвэл газар дор булдаг байсан Хятад улсын наймаачдаас үүсэлтэй гэж үздэг бөгөөд мөнгө угаах арга хэлбэрүүд нь цаг хугацааны явцад боловсронгуй болсоор ирсэн. Мөнгө угаах гэсэн нэр томъёо 1920-оод оны эхэнд АНУ-ын мафиин толгойлогч Аль Капоне хууль бус үйлдлээсээ олсон хөрөнгөө өөрийн угаалгын газраас олсон орлого мэтээр тайлагнадаг байснаас эхлэн бий болсон хэдий ч АНУ-ын Банкны нууцлалын тухай хуулийг 1970 онд баталснаас хойш энэхүү ойлголт албан ёсоор бий болсон гэж үздэг.

Монгол Улсад мөнгө угаахтай тэмцэх асуудал харьцангуй хожуу буюу 2006 оны 7 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хурлаас Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг батлан мөрдүүлснээр уг гэмт хэрэгтэй тэмцэх эхлэл болсон.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд санхүүгийн

байгууллагуудын оролцоо хамгийн чухал учир мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгайлан авч үзэн мэдээлэх үүрэгтэй этгээд гэж хуульд тодорхойлсон байдаг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд банк бус санхүүгийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, мөн санхүүгийн бус бизнесийн үйл ажиллагаа болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажилд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавихаар заасан байдаг.

Иймд СЗХ-ноос хяналт тавих мэдээлэх үүрэгтэй этгээдийн үйл ажиллагаанд зайнаас болон газар дээрх хяналт шалгалт хийх

зорилгоор 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 339 дүгээр тогтоолоор “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Уг журмын агуулга нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалтыг хийхдээ олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн үнэлгээг хийх агуулга, матриц, аргачлалыг ашиглахаар зохицуулснаараа онцлог юм.

Журмын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэхүү журмын зорилго нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-4.1.8-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан журам, заавраар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, эрсдэлд суурилсан

хяналт шалгалтын зарчмын дагуу зайнаас болон газар дээр нь хяналт шалгалт хийж дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах зэрэг юм.

Журмын төсөл нь 4 бүлэгтэй бөгөөд 1 дүгээр бүлэгт Нийтлэг үндэслэл буюу журмаар зохицуулагдах харилцаа, хяналт шалгалтын төрөл, хэлбэрийг 2 дугаар бүлэгт зайнаас хяналт тавихтай холбоотой харилцааг, 3 дугаар бүлэгт газар дээрх хяналт шалгалт хийхтэй холбоотой харилцааг, 4 дүгээр бүлэгт Хариуцлагын талаарх зохицуулалтыг тус тус тусгасан болно.

Журамд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар

Улс орны мөнгө угаах болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааг Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага /ФАТФ/ нь Техникийн хэрэгжилтийн 40 зөвлөмж, Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн биелэлтээр дүгнэдэг. Монгол Улсын хувьд 2019 оны 10 дугаар сард хэвлэгдэн гарсан Дахин үнэлгээний тайлангаар хэрэгжээгүй үзүүлэлт байхгүй, хэсэгчлэн биелсэн буюу сайжруулах шаардлагатай 5 үзүүлэлт байна. 2019 оны 10 дугаар сарын 18–ны

өдөр ФАТФ ээлжит хурлаараа Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад оруулсныг нийтэд зарлаж хугацаатай эрчимжүүлэх ажлын хүрээнд 4 даалгаврыг өгсөн.

Монгол Улсад өгсөн Ажлын даалгаварт “Хяналт шалгалт”–ыг эрчимжүүлэх чиглэл өгсөн. Үүнтэй холбоотойгоор Хорооноос ажлын даалгаврыг биелүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, шат дараалсан арга хэмжээ авч ажиллаж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 12 дугаар сарын 27–ны өдрийн 438 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”–д нэмэлт, өөрчлөлт оруулж мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийн үнэлгээг хийх шинэ зохицуулалт нэмсэн бол зайны болон газар дээрх хяналт шалгалтын хэлбэрүүдэд нэмэлт оруулж, тайлан мэдээг танилцуулах, мэдээлэхтэй холбоотой заалтуудад холбогдох өөрчлөлтийг оруулан дагаж мөрдүүлж байна.

ФИНТЕК БА РЕГТЕК

Machine learning буюу машин сургалт

Машин сургалт /machine learning/ гэдэг нь статистик загварууд, алгоритм, тооцооллын системийг ашиглан өгөгдсөн мэдээлэл, түүний зүй тогтол зэрэг дээр үндэслэн ямар нэгэн зааварчилгаагүйгээр тодорхой нэгэн ажил, даалгаврыг гүйцэтгэхийг хэлнэ. Машин сургалтыг “спам” мэйлүүдээ ялгах аас эхлээд залилан луйврыг илрүүлэх, хувьцааны үнэ таамаглах зэрэг олон зорилгоор ашиглаж байна.

Машин сургалт нь ерөнхийдөө 3 зүйлийг ашигладаг нь өгөгдөл, хувьсагч, алгоритм юм.

Өгөгдөл буюу data: Спам мэйлээ ялгамаар байвал спам мэйлийн хэд хэдэн жишээтэй болох хэрэгтэй, хувьцааны үнийг таамагламаар байвал хувьцааныхаа үнийн түүхийг цуглуулах шаардлагатай. Хэдий чинээ өргөн хүрээний өгөгдөл байна, төдий хэмжээгээр үр дүн сайн гарна.

Хувьсагч буюу features: Машины явсан зам, хэрэглэгчийн хүйс, хувьцааны үнэ, өгөгдсөн текст дэх үгийн давтамж зэрэг юу ч байж болох бөгөөд өгөгдлийн сангаас машин сургалтын хайх ёстой зүйлийг хэлнэ.

Алгоритм: Өгөгдсөн мэдээлэл болон эцсийн үр дүн нь юу байхаас хамааран өөр өөр төрлийн алгоритмыг сонгох шаардлагатай болно. Машин сургалтын алгоритм ерөнхийдөө хэд хэдэн төрөлтэй байдгаас хяналттай сургалт /supervised learning/ болон хяналтгүй сургалт /unsupervised learning/ гэсэн 2 ангиллыг авч үзье. Хяналттай сургалтын хувьд нөгөөхөөсөө ялгаатай нь ямар үр дүнд хүрэхийг нь зааж өгөх “хянагч”–тай байна. Жишээ нь зурганд муур, нохой 2–ын аль нь байгаа гэдгийг машин өгөгдсөн мэдээллийг ашиглан тодорхойлох шаардлагатай гэсэн үг. Энэ тохиолдолд гарах үр дүн буюу хариулт нь муур эсвэл нохой гэж тодорхойлогдсон байна. Харин хяналтгүй сургалтын хувьд машин олон амьтны зураг дундаас юу нь юу вэ гэдгийг ямар нэгэн зүй тогтлыг тогтоон илрүүлэх замаар олохыг хэлнэ.

Хяналттай машин сургалт

Хяналттай сургалт нь ерөнхийдөө 2 төрлийнх байдаг нь ангилал /classification/ бөгөөд регресс /regression/ бөгөөд ангиллаас гарах үр дүн нь тодорхой чанарын утга авах, регрессээс гарах үр дүн нь тодорхой интервалд авах тоон утга байдгаараа ялгаатай.

Хяналттай машин сургалтыг ямар салбаруудад ашигладаг вэ?

1. Био–информатик буюу био мэдээлэл – Хүний хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүрний хэлбэр зэрэг биологийн мэдээллийг хадгалах үйлдлийг хэлдэг ба бид энэ хяналттай сургалтыг ашигласан технологийг өдөр тутамдаа хэрэглэдэг. Орчин үеийн ухаалаг гар утаснууд бидний биологийн мэдээллийг хадгалж аван системийн нууцлалыг сайжруулах нүүр таних /facial recognition/ эсвэл хурууны хээ мэдрэх зэрэг үйлдлүүдийг нэвтрүүлсэн байдаг.
2. Хоолой таних буюу speech recognition – Алгоритмдаа өөрийн хоолойг зааж, өөрийг чинь танихад сургана гэсэн үг юм. Бодит амьдрал дээр Google Assistant, Siri зэрэг зөвхөн өөрийн тань хоолойнд хариу үйлдэл үзүүлэх програмууд байдаг.
3. Спам илрүүлэлт – Өмнө нь дурдсанаар спам мэйлийг ялгахад машин сургалтыг ашигладаг. Жишээ нь G–Mail–ийн хувьд спам мэйлд ихэвчлэн байдаг хэд хэдэн түлхүүр үгийг олдог алгоритм байдаг бол OnePlus Messages аппликэйшний хувьд ямар түлхүүр үгсийг хэрэглэгч өөрөө зааж өгөн, тухайн үгс орсон мэйлийг цаашид зохих байдлаар ангилдаг.

Хяналттай машин сургалтын сул талууд:

- Машиныг сургахын тулд сайн жишээ болохоор өгөгдлүүдийг ашиглах шаардлагатай;
- Суралцах хугацаа ихээр шаардах тохиолдлууд бий;

- Буруу өгөгдлийг оруулснаар үр дүнгийн нарийвчлалыг алдагдуулдаг;
- Өгөгдлийг урьдчилан бэлтгэх нь хүндрэлтэй;
- Өгөгдлийн сан алдаатай бол алгоритм буруу “сурах” эрсдэлтэй.

Хяналтгүй машин сургалт

Энэ төрлийн машин сургалтыг ихэнхдээ харьцангуй өргөн хүрээний өгөгдөлтэй үед хүний ажлыг хөнгөвчлөх үүднээс хяналттай машин сургалтын оронд ашигладаг. Алгоритм өгөгдөл дээр байж болох бүхий л зүй тогтлыг илрүүлэн суралцах үйл явцыг хяналтгүй машин сургалт гэнэ. Хяналтгүй машин сургалтын хамгийн түгээмэл төрөл нь “clustering” буюу өгөгдлийн ижил төстэй шинж чанарын төвлөрөл, бөөгнөлийг олох алгоритм байдаг. Ангиллаас ялгаатай нь машинд ямар нэгэн гарах үр дүнгийн өгөгдлийг өгөхгүйгээр анхны өгөгдөл дээр өөрийг нь ажиллуулж зүй тогтлыг нь олуулах үйлдэл хийгддэг тул хяналтгүй машин сургалт гэж үздэг.

Хяналтгүй машин сургалтыг ямар салбаруудад ашигладаг вэ?

1. Anomaly detection буюу хэвийн бус үзэгдлийг илрүүлэх – Хөрөнгийн зах зээлд дотоод мэдээлэлтэй оролцогчийн гаргаж буй үйлдлүүд нь бусад оролцогчдынхоос ялгаатай байдаг. Хяналтгүй машин сургалтыг ашигласнаар тус дотоод мэдээлэл эзэмшигчийг илрүүлэх боломжтой байдаг.
2. Зах зээлийн сегментчлэл – Хэрэглэгчдийн хэрэглээний ижил төстэй шинж чанарыг ашиглан зах зээлийг хэд хэдэн бүлэгт хувааж, тэдэнд тус бүрт нь харгалзах стратегийг боловсруулах нь компанийн хувьд хамгийн ашигтай байна. Хяналтгүй машин сургалтыг ашиглан хэрэглээний мэдээллийг боловсруулан зах зээлийг сегментчлэх боломжтой байдаг.

Хяналтгүй машин сургалтын сул талууд:

- Анхнаасаа өгөгдлөөс гарах мэдээллийг тодорхойлж өгөөгүй байдаг учир тодорхой нарийн мэдээллийг авах боломжгүй;
- Гарсан үр дүн болон ангиллыг цаашид ашиглах, боловсруулах үйлдлийг хэрэглэгч өөрөө хийнэ;
- Ангилал цаг хугацааны үе бүрт өөрчлөгдөх боломжтой байдаг.

| | ХЯНАЛТТАЙ | ХЯНАЛТГҮЙ |
|-----------------------------------|--|---|
| Өгөгдөл | Алгоритмд тодорхой өгөгдлийн шинж чанарын талаар зааж өгөх ёстой | Алгоритм өгөгдлийн ямар ч шинж чанарын талаар мэдээлэлгүй |
| Тооцооллын нарийн төвөгтэй байдал | Харьцангуй хялбар, энгийн арга | Тооцоолол нь нарийн бөгөөд төвөгтэй |
| Нарийвчлал | Нарийвчлал сайтай, найдвартай | Харьцангуй муу нарийвчлалтай |

Машин сургалт болон финтек

Форбес сэтгүүлээс гаргасан 2020 онд финтекийн салбарыг хиймэл оюун ухаан тэр дундаа машин сургалт хэрхэн сайжруулах талаарх нийтлэлээс хүргэж байна.

1. Зээлийн түүхгүй Z үеийнхэн /23–36 насныхан/ нэмэгдэж байгаагаас болоод зээлийн байгууллагууд машин сургалтыг ашиглах болжээ. АНУ-ын Юта мужид байрлалтай Prestige санхүүгийн үйлчилгээний компани зээлийн үйлчилгээндээ хиймэл оюун ухааныг нэвтрүүлэн 19–35 насны хүмүүсээс зээлдэгчдийг ялгахыг зорьжээ. Үр дүнд нь тэдний зээл олголт 25 хувиар нэмэгдэж 20-оос доош насны зээлдэгчдийн тоо 3 дахин өссөн байна.
2. Орон сууц худалдан авах хамгийн их сонирхолтой хүмүүс буюу Z үеийнхэн ихсэж байгаагаас шалтгаалан үл хөдлөх хөрөнгө анх удаа худалдан авч байгаа хүмүүст өгөх орон сууцны зээлд хиймэл оюун ухааныг ашиглах болжээ. Зээлийн судалгааны байгууллага болох TransUnion-оос гаргасан судалгааны үр дүнд Z үеийнхний орон сууц худалдан авах сонирхол нь X үеийнхнээс өндөр байгааг харуулсан бөгөөд үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниуд зорилтот худалдан авагчдыг олж илрүүлэхэд машин сургалт болон хиймэл оюун ухааныг ашиглах боломжтой гэж үзээд байна.
3. Банк болон санхүүгийн бусад байгууллагууд машин сургалтыг ашиглан үйл ажиллагааны зардлаа бууруулж байна. Зээлийн эрсдэлийн загвартаа ашигладаг өгөгдлөөс аль нь хамгийн хэрэгтэй буюу нөлөөтэй вэ гэдгийг машин сургалтыг ашиглан үнэлэх боломжтой. Ингэснээр загвартай холбоотой өгөгдөл цуглуулах, үнэлэхэд гарах зардлыг бууруулж чадна гэж үзэж байна.
4. Комплайнсын зардлыг бууруулах. Санхүүгийн байгууллагууд хууль, дүрэм, журам засаглалын шаардлагад нийцэхийн тулд Комплайнсын багийн хэдэн долоо хоногоор хийдэг ажлыг машин сургалтын алгоритмыг ашиглан хэдэн минутанд ч хийх боломжтой.
5. Зээлийн эргэн төлөлтийг зээлдэгч болгоноос нь хамааруулж авах арга хэмжээг ялгах. Хугацаа хэтэрсэн зээлдэгчдийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг тооцоолох боломжтой. Жишээ нь Zest хиймэл оюун ухааны компанийн гаргасан машин сургалтыг нэг банк ашиглаж зээлийн эргэн төлөгдөх хугацааг нарийн тооцоолж чадсан байна. Ингэхдээ зээлдэгч болгоноор тухайн мэдээллийг боловсруулан, зээлдэгчдийн ангиллыг тухай бүр шинэчлэн зээлийн эргэн төлөлтийг сайжруулсан байна.

СУДЛААЧИЙН ИНДЭР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛД “MILES–EZZELL БОЛОН MODIGLIANI–MILLER”-ИЙН ЗАСВАРЛАЛТЫГ АШИГЛАХ НЬ:

Д. ГАНБАЯР, УДИРДАГЧ БАГШ: Г. БАТТУЛГА

Энэхүү бүтээл нь СЗХ-ноос 2019 оны 11 дүгээр сард зохиогдсон “Эрдэм шинжилгээний хурал”-ын оюутны ангилалд тэргүүн байр эзэлсэн бүтээл бөгөөд уг судалгаа нь СЗХ-ны байр суурийг илэрхийлээгүй болно.

Хураангуй:

Санхүүгийн менежментийн гол зорилго нь “ашгийг нэмэгдүүлэх”-д бус харин “Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө баялгийг хамгийн ихээр өсгөж, арвижуулах”-д чиглэсэн байх ёстой. Иймд шинээр анхдагч зах зээлд хувьцаагаа гаргаж буй компаниудын үнэлгээнд бизнесийн болон санхүүгийн эрсдэлийг хэрхэн бага байлгах нь онолын судлаачид болон мэргэжлийн үнэлгээ хийгчдэд зайлшгүй тулгардаг асуудал юм. Энэхүү онолын болон эмпирик судалгааны явцад хөшүүрэгжсэн болон хөшүүрэгжээгүй компаниудын үнэлгээг “Miles–Ezzell болон Modigliani–Miller”-ийн засварлалтаар үнэлэх, энэ засварлалт нь үнэхээр практикт эрсдэлийг бууруулж чадаж байгаа эсэхэд хариулт олохыг зорьсон. Эмпирик судалгааны хүрээнд Монголын Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж буй 14 компанийн зах зээл дээрх өгөөж болон эрсдэлийг тооцоолж, хөрөнгийн зах зээлийн хөөсрөлд анализ хийсэн. Компанийн анхдагч үнэ цэнийн эрсдэлийг бууруулахдаа Онолын хувьд эрсдэл саармагжуулах магадлалын хэмжээсийг ашиглах ба энэ нь хөрөнгийн үнэлгээний дискаунтын хувийг зах зээлийн эрсдэлгүй хүүтэй тэнцүү гэсэн тэнцлийг батална. Ингэснээр хөрөнгийн зах зээл дээрх компанийн эрсдэлийг бууруулж байгаа юм. Компанийн санхүүжилтийн хэлбэр бүрт өөр өөр үнэлгээний тэгшитгэл өгөх ба энэхүү судалгаагаар үндсэн гурван төрлийн санхүүжилтийн хэлбэрийг авч үзсэн. Санхүүжилтийн хувилбар бүр дээр хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй “Түмэн Шувуу” ХК-ийн үнэлгээг дээрх аргачлалаар дахин хийж анх үнэлсэн үнэлгээ болон өнөөгийн зах зээлийн үнэ цэнэд шууд харьцуулж үнэлэлт дүгнэлт өглөө.

Түлхүүр үгс: Компанийн үнэлгээ, эрсдэл саармаг магадлалын хэмжээс, дискаунтын хувь, капиталын өртөг, “Miles–Ezzell & Modigliani–Miller”-ийн засварлалт, хөшүүрэг, өрийн харьцаа.

Удиртгал

Компанийн үнэлгээ нь мөнгөн гүйлгээ, татвар, капиталын өртөг гэсэн гурван зүйлийг детерминистик байхыг шаарддаг. Мөн компани бүрт зайлшгүй хүндэтгэн үзэх шаардлагатай хоёр төрлийн эрсдэл байдаг. Үүнд бизнесийн болон санхүүгийн эрсдэлийг багтаан ойлгох ба санхүүгийн эрсдэл нь хөшүүргийн харьцаагаараа ялгаатай. Санхүүгийн эрсдэлийг эхлээд хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртгийг тодорхойлж /unlevering/, дараа нь хөшүүрэгжсэн компанийн капиталын өртгийг тодорхойлох /relevering/ замаар арилгадаг. Хөшүүрэгжээгүй гэдэгт ирээдүйд төлөх ямар ч өр төлбөр байхгүйг багтаан ойлгоно. Иймд санхүүгийн эрсдэлийг арилгахад капиталын өртгийг тодорхойлох нь нэн тэргүүний асуудал гэдэг нь ойлгомжтой

байна. Харин капиталын өртөгт нөлөөлөгч хүчин зүйлсэд өр төлбөр болон бизнесийн эрсдэл хамаарна. Бизнесийн эрсдэлийг хөрөнгийн зах зээлээс ижил төстэй компанийн эрсдэлийн ангиллаар авч болно. Өрийн тухайд өр болон өмчийн харьцаа нь их байвал эрсдэл ихтэй мөн төдий чинээ өгөөж өндөртэйг илтгэнэ. Гэхдээ өр нь капиталын өртөгт нөлөөлнө гэж үзвэл харьцуулах компанийн капиталын өртгийг үнэлэх шаардлагагүй. Өр ихтэй компани нь тодорхой мөчлөгөөр тодорхойлогддог бөгөөд аливаа нөхцөл байдалд ижил төстэй мөнгөн гүйлгээтэй хөрөнгө оруулалтын санхүүжилт бүхий компаниас илүү үнэ цэнэтэй байдаг. Тиймээс өрийг өсгөх нь компанийн үнэ цэнийг өсгөх хөшүүрэг болдог. Иймд өр төлбөрийг барьцаалан хөшүүрэглэх тэгш эрхээр хангах гэдэг утгаар хэрэглэнэ.

Онолын хувьд хөрөнгийн үнэлгээний дискаунтын хувийг зах зээлийн эрсдэлгүй хүүтэй тэнцүү гэсэн тэнцлийг ашиглана. Энэ тэнцэл нь “Risk neutrality” буюу эрсдэл саармаг магадлалын хэмжээсээр тооцсон үнэлгээ нь засварлалт ашигласан үнэлгээтэй нэгэн утгатайгаар оршин байна гэсэн тэнцэлд тулгуурлах ба компанийн санхүүжилтийн бодлогоос хамааран дараах онолын тэгшитгэлүүдийг өгнө.

1. ХӨШҮҮРЭГЖЭЭГҮЙ КОМПАНИ

Тодорхойлолт 1 /Хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртөг/: Хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртөг нь өмчийг t хугацаан дахь өмчөөс $t+1$ хугацаан дахь өмчийн хэмжээнд хүргэхэд шаардагдах капиталыг илэрхийлэх ба дараах хэлбэрээр тодорхойлогдоно.

$$k_t^{E,u} := \frac{E[FCF_{t+1}^u + V_{t+1}^u | F_t]}{V_t^u} - 1$$

Теорем 1: /Хөшүүрэгжээгүй компанийн зах зээлийн үнэ цэнэ/ Капиталын өртөг детерменистик үед дараах тэгшитгэлтэй.

$$V_t^u = \sum_{s=t+1}^T \frac{E[FCF_s^u | F_t]}{1 + k_t^{E,u} / \dots / 1 + k_{s-1}^{E,u} /}$$

$k_t^{E,u}$: Эргэлтийн бус капиталын өртөг

V_t^u : Зөвхөн өмчлөгчийн өмчөөс санхүүждэг компанийн үнэ цэнэ.

$t = 0$ үед Сонгодог хүлээлт

Таамаглал 1 /Сул авторегрессив мөнгөн гүйлгээ/: Хөшүүрэгжээгүй компанийн мөнгөн гүйлгээ сул авторегрессив байна.

$$FCF_{t+1}^u = (1 - g_t)FCF_t^u + \varepsilon_{t+1}$$

Уг таамаглалын зорилго нь хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртөг /хүлээгдэж буй өгөөж/ нь дискаунтын хувь байна гэдгийг харуулах юм. Гол санаа нь өдөр тутмын бизнес нь статистикийн хувьд өмнөх үеийн мөнгөн урсгалаасаа хамааралтай гэсэн санаа. Энэ таамаглал нь хөшүүрэгжээгүй компанийн стохастик бүтцийг авч үзнэ. <<Авторегрессив мөнгөн гүйлгээ>> AR/1/ гэж тэмдэглэнэ.

$$\text{Алдаанд тавигдах нөхцөл: } Cov(\varepsilon_t, \varepsilon_s) = 0, \quad E[\varepsilon_t] = 0$$

Энд эпслион буюу шуугианыг хос хосоороо үл хамаарах байна гэж үзнэ. Корреляци хамааралгүй гэдэг нь үл хамаарах гэсэн үг биш гэдгийг анхаарах хэрэгтэй. Үл хамаарах гэдэг нь шуугианы дурын хос бүрт ямар ч функцээр үйлчилсэн дахиад корреляци хамааралгүй байхыг хэлнэ. Иймд нөхцөлт хүлээлт авахад өсөлтийн хувь цаг хугацаанаас хамааралтай байж болохыг илтгэх ба **Таамаглал 1** биелэх нь харагдаж байна. Сул авторегрессив мөнгөн гүйлгээ нь дараах хоёр чухал теоремыг өөртөө багтаана.

- Ногдол ашиг болон үнийн харьцаа нь детерминистик
- Хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртгийг дискаунтын хувь болгон ашиглаж болно.

Теорем 2: /Үнэлгээний үзэл баримтлалуудын тэнцэл/ Хэрэв капиталын өртөг тодорхой мөнгөн гүйлгээ нь сул авторегрессив бол дээр хэлсэнчлэн дараах хоёр тэгшитгэл ижил үнэлгээ өгнө.

$$\frac{E_Q[FCF_s^u | F_t]}{1 + r_f / s - t} = \sum_{s=t+1}^T \frac{E[FCF_s^u | F_t]}{1 + k_t^{t \rightarrow s} / \dots / 1 + k_{s-1}^{t \rightarrow s}}$$

Энд эрсдэл саармагжуулах магадлалын хэмжээс Q-г оруулж ирснийг анхаарах хэрэгтэй. Q-гийн ямар ч утганд үнэлгээний тэгшитгэл нэгэн утгатай байна. Энэ өгүүлбэр нь зах зээлийн эрсдэлгүй хүүг дискаунтын хувьтай тэнцүү гэдгийг харуулна.

2. ХӨШҮҮРЭГЖСЭН КОМПАНИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Хөшүүрэгжсэн болон хөшүүрэгжээгүй компаниудын хувьд татвар нь ялгаатай байдаг. Энэхүү татварын ялгаа нь компанийн үнэ цэнэд нөлөөлдөг. Хөшүүрэгжсэн компанийн хувьд өр болон өмчийг тусгаарлан авч үзэх хэрэгтэй.

Орлого болон татвар

Хөшүүрэгжсэн болон хөшүүрэгжээгүй компаниудын төлөх татварын ялгаа нь дараах тэнцлээр биелэх ба үүнийг татварын бамбай гэж санхүүд нэрлэдэг. $Tax_t^u - Tax_t^l = \tau I_t$ Иймд энэ зөрүү нь хөшүүрэгжсэн компанийн хувьд цэвэр мөнгөн гүйлгээн дээр нэмэгдэнэ гэсэн үг бөгөөд хөшүүрэгжээгүй компаниас илүү үнэ цэнэд хүрдэг нэг шалтгаан юм. $FCF_t^l = FCF_t^u + \tau I_t$ Бидний зорилго бол татварын бамбай бүхий ерөнхий үнэлгээний тэгшитгэл бичих бөгөөд хөшүүрэгжсэн болон хөшүүрэгжээгүй компанийн үнэлгээнд татварын бамбайг ашиглавал гаргалгаа нь дараах тэгшитгэлд хүргэнэ.

$$V_t^{l,u} = \frac{E_Q[FCF_{t+1}^{l,u} + V_{t+1}^l | F_t]}{(1 + r_f)} \Rightarrow FCF_t^l = FCF_t^u + \tau I_t \Rightarrow$$

$$\Rightarrow V_t^l - V_t^u = \frac{E_Q[\tau I_{t+1} + V_{t+1}^l - V_{t+1}^u | F_t]}{1 + r_f}$$

Таамаглал 2 /Өр төлбөрийг эрэмбэлэх/: Мөнгөн гүйлгээ нь татварын өр төлбөрийг төлөхөд хангалттай гэж үзнэ. Татварын алба татварын хүүг тогтоодог, ингэхдээ өрийг хүчингүй болгож татвар ногдуулах баазад нэмнэ. Иймд дефолт болох эрсдэлтэй компанийн төлөх татвар дараах байдлаар өгөгдөнө.

$$Tax_{t+1}^l = \tau / GCF_{t+1} - Accr_{t+1} - I_{t+1} + D_t - D_{t+1} - R_{t+1} /.$$

D_t^{\sim} - t агшин дахь зээлийн үлдэгдэл R_{t+1}^{\sim} - t+1 агшинд буцаан төлөгдөх дүн I_{t+1}^{\sim} - t+1 агшинд төлөх хүү.

Нийт мөнгөн гүйлгээ болон хөрөнгө оруулалтын зардал нь хөшүүрэгжээгүй компанитай төстэй тул хөшүүрэгжсэн компанийн цэвэр мөнгөн гүйлгээг үнэлгээний тэгшитгэлдээ орлуулбал дээрх тэгшитгэл гарна.

$$V_t^l = \sum_{s=t+1}^T \frac{E_Q[FCF_s^l | F_t]}{1 + r_f / s - t} = V_t^u + \sum_{s=t+1}^T \frac{\tau E_Q [I_s - D_{s-1} + D_s + R_s | F_t]}{1 + r_f / s - t}.$$

2.1 Өөрийн хөрөнгөд суурилсан санхүүжилт

Теорем 3: /Засварлагдсан өнөөгийн үнэ цэнэ/ Бие даасан санхүүжилтийн хувьд дараах тэгшитгэл нь хөшүүрэгжсэн компанийн зах зээлийн үнэ цэнэд ямар ч үед хүчинтэй байна.

$$V_t^l = V_t^u + \sum_{s=t+1}^T \frac{\tau r_f D_{s-1}}{1 + r_f / s - t}$$

Теорем 4: /"Modigliani – Miller"-ийн томъёо/ Хэрэв компанийг үүрд оршин тогтноно гэвэл **Теорем 3**-ын нөхцөлүүд хангагдаж өр нь тогтмол байна. Энэ тохиолдолд зах зээлийн үнэ цэнэд дараах зарчим үйлчилнэ.

$$V_t^l = V_t^u + \tau D_t \Rightarrow V_0^l = V_0^u + \tau l_0 V_0^l = (1 - \tau l_0) V_0^l = V_0^u$$

$$(1 - \tau l_0) V_0^l = \frac{E[FCF^u]}{k^{E,u}} \Rightarrow V_0^l = \frac{E[FCF^u]}{(1 - \tau l_0) k^{E,u}}$$

2.2 Зах зээлийн үнэ цэнэд суурилсан санхүүжилт

Тодорхойлолт 2 /Зах зээлийн үнэ цэнэд суурилсан санхүүжилт/: Өрийн харьцаа нь тодорхой биш бол санхүүжилт нь зах зээлийн үнэ цэнэд суурилсан байна. Энэ тохиолдолд ирээдүйн өр төлбөрийн хэмжээ болон өрийн татварын давуу тал тодорхойгүй байна. Мөн засварлагдсан өнөөгийн үнэ цэнийг ашиглаж болохгүй ба үүний оронд гурван янзын капиталын өртгийг тодорхойлж болдог. Хөрөнгө оруулалтын <<зохистой>> өртөгт өмчийн өртөг, Нийт мөнгөн гүйлгээ, КЖДӨртөг гэсэн үнэлгээний гурван аргачлалыг багтаан ойлгож болно. Өмчийн өртөг нь хувьцаа эзэмшигчдийн өмч хөрөнгийн өртгийг харуулдаг ба өмчөөс гадна хөшүүрэгжсэн компанийн мөнгөн гүйлгээ, буцаан төлөлт болон хүүг детерминистик байхыг шаарддаг.

Тодорхойлолт 3 /Хөшүүрэгжсэн компанийн капиталын өртөг/:

Өмчийн өртөгийн нөхцөлт хүлээлт:

$$k_t^{E,l} := \frac{E[E_{t+1} + FCF_{t+1}^l - I_t - R_{t+1} | F_t]}{E_t} - 1$$

Теорем 5: /Өмчийн өртөг: Өмчийн өртөг детерминистик бол t агшин дахь өмч:

$$E_t = \sum_{s=t+1}^T \frac{E[FCF_s^l - I_s - R_s | F_t]}{1+k_t^{E,l} / \dots / 1+k_{s-1}^{E,l}}$$

Тодорхойлолт 4 /Капиталын жигнэсэн дундаж өртөг – төрөл 1/: Хөшүүрэгжсэн компанийн капиталын өртөгийн нөхцөлт хүлээлт:

$$k_t^\emptyset := \frac{E[FCF_{t+1}^l + V_{t+1}^l | F_t]}{V_t^l} - 1$$

Теорем 6: /Нийт мөнгөн гүйлгээ/: Хэрэв КЖДӨртөг төрөл – 1 детерминистик бол хөшүүрэгжсэн компанийн үнэлгээ:

$$V_t^l = \sum_{s=t+1}^T \frac{E[FCF_s^l | F_t]}{1+k_t^\emptyset / \dots / 1+k_{s-1}^\emptyset}$$

Тодорхойлолт 5 /КЖДӨ төрөл – 2/: Хөшүүрэгжсэн компанийн капиталын өртгийн нөхцөлт хүлээлт

$$WACC_t := \frac{E[FCF_{t+1}^u + V_{t+1}^l | F_t]}{V_t^l} - 1$$

2.3 “Milles Ezell”-ийн засварлалт

Зах зээлийн үнэ цэнэд суурилсан санхүүжилт хийж байгаа тохиолдолд FTE, TCF, WACC нь заримдаа давхцаж зарим тохиолдолд давхцдаггүй. WACC болон хөшүүрэгжээгүй капиталын өртөгийн хооронд дох харьцааны талаар юу хэлж болох вэ? Энэ асуулт нь “Miles-Ezzell” болон “Modigliani-Miller”-ийн засварлалт гэсэн сэдэв рүү хөтөлдөг. Нэг зайлшгүй шаардагдах зүйл нь мөнгөн урсгалыг сул авторегрессив гэсэн таамаглал биелэх явдал юм.

Теорем 7 /Miles-Ezzell 1980/: Хэрэв хөшүүрэгжээгүй компанийн мөнгөн гүйлгээ сул авторегрессив бол хөшүүрэгжсэн компани зах зээлийн үнэ цэнээс хамааран санхүүждэг ба КЖДӨ нь тодорхойлогдохдоо дараах хэлбэрээр бичигдэнэ. Хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртөг детерминистик байна.

$$1 + WACC_t = (1 + k_t^{E,u}) \left(1 - \frac{rr_f}{1+rr_f}\right)$$

2.4 “Modigliani Miller”-ийн засварлалт

Теорем 8 /Modigliani-Miller 1963/: Энэ засварлалт нь тогтмол хөшүүрэгжийн харьцаа шаарддаг ба $WACC=WACC$ type 2 болон хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртгөөр тодорхойлогддог. Компани нь зах зээлийн үнэ цэнээс хамааран санхүүжих болон өр тогтмол байх мөн хязгааргүй оршин тогтноно гэсэн хоёр таамаглалыг зайлшгүй шаарддаг.

$$WACC = k^{E,l}(1 - \tau_l) \quad \left(\text{“Modigliani Miller” тэй харьцуулбал } V_0^l = \frac{E[FCF^u]}{(1 - \tau_l)k^{E,u}} \right)$$

“Modigliani-Miller”-ийн засварлалтыг хэрэглэхийн тулд WACC болон хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртгийг хоёуланг нь тодорхойлох шаардлагатай.

3. ДАНСНЫ ҮНЭ ЦЭНЭД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ

КЖДӨ нь компанийг үнэлэх хамгийн түгээмэл арга боловч зах зээлийн үнэ цэнийг тодорхойлох хөшүүрэг шаарддаг. “Хэрэв бид үнэлгээний тэгшитгэлтэй бол зах зээлийн үнэ цэнийг дансны үнэ цэнээр сольж болох уу?” гэх асуулт урган гарч болох ба энэ нь дансны үнэ цэнэд суурилсан санхүүжилт гэсэн ойлголттой холбогдоно. Дансны өмчийг зах зээлийн өмчөөс ялгаатай гэж үзэх ба түүнд захиалсан капиталын өртөг, татварын дараах орлого, хувьцаа эзэмшигчид мөнгөн гүйлгээнээс олгогдсон ногдол ашиг гэсэн гурван хүчин зүйлс нөлөөлнө.

Дансны үнэ цэнэд суурилсан санхүүжилтийн хүрээнд хүү болон татварын дараах ашиг болон хувьцаа эзэмшигчдийн авах ногдол ашиг нь тэнцүү буюу компани олсон ашгаа бүгдийг нь ногдол ашиг болгон тараадаг зах зээлийн үнэ цэнэд суурилсан бүрэн хуваарилалтын бодлого болон мөнгөн гүйлгээнд суурилсан хөрөнгө оруулалтуудыг авч үзсэн. Мөнгөн гүйлгээнд суурилсан хөрөнгө оруулалтын бодлогын гол санаа нь хугацааны агшин бүрт мөнгөн гүйлгээнээс альфа хэмжээгээр санхүүжилт нэмж хийнэ гэсэн санаа юм. Ингэхдээ элэгдэл хорогдолд зарцуулахгүйгээр тусгах ёстой ба хэрэв дахин санхүүжилт хийдэггүй бол хөрөнгө оруулалтыг тэгээр авна. Гэхдээ элэгдэл хорогдол нь хугацааны агшин бүрт өрийн харьцааг нормчлох ба энэ нь мөнгөн гүйлгээнд нөлөөлнө гэдгийг санах хэрэгтэй.

4. ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

4.1 Хөшүүрэгжээгүй компанийн үнэлгээ

Компанийн үнэлгээний онолыг практикт хэрэгжүүлэхийн тулд 2018 онд анхдагч үнийн зах зээлд хөл тавьсан “Түмэн Шувуут” ХК-ийн тоон мэдээлэл дээр “Milles Ezell & Modigliani Miller” нарын засварлалт бүхий үнэлгээний тэгшитгэлд тулгуурлан дахин шинжилгээ хийсэн ба энэ явцад гарсан хүндрэл нь тухайн компани 5 тэрбум төгрөгийн зээлтэй ба үүн дээрээ тулгуурлан балансаа тооцсон тул өрийг балансаас хасаж зарим шаардлагатай мэдээллүүдийг шугаман загвараар прогноз хийх шаардлага гарсан. Хөшүүрэгжээгүй компанийн капиталын өртөг нь өмчийг t хугацаан дахь өмчөөс $t+1$ хугацаан дахь өмчийн хэмжээнд хүргэхэд шаардагдах капиталын өртөг юм. Иймд хөшүүрэгжээгүй компанийн эздийн өмчийн мэдээлэл хэрэгтэй ба 2013 – 2017 оны эздийн өмчийн мэдээлэл дээр үндэслэн 2022 он хүртэл прогнозлосон ба нэмж татан төвлөрүүлэх хөрөнгө 10 тэрбум төгрөгийг нэмж тооцсон. Шугаман загварын детерминац 0.88 гарсан ба өр төлбөр байсан үеийн эздийн өмчийн хувьд 0.994 байсан. Цэгэн прогнозын хувьд налалтын коэффициент болон огтлогч бага зэрэг зөрүүтэй байсан ч ерөнхий трендийн хувьд ойролцоогоор маш ойрхон байсан. Эндээс капиталын өртгийг хугацааны агшин бүрт тооцон дунджаар авсан ба 19.2 гарсан. Энэ өртөг дээр засварлалт хийх замаар хөшүүрэгжсэн компанийн үнэлгээг хийсэн.

4.2 Хөшүүрэгжсэн компанийн үнэлгээ

“Түмэн Шувуут” ХК нь урт хугацааны 8 хувийн 3 тэрбум төгрөгийн зээлтэй ба богино хугацааны 18 хувийн 2 тэрбум төгрөг, нийт 5 тэрбум төгрөгийн өр төлбөртэй байсан.

Өөрийн хөрөнгөнд болон зах зээлийн үнэ цэнэд суурилсан санхүүжилт

| | Autonomous Financing | | Financing Based on Market Values | | | |
|----------------------|----------------------|-------------|----------------------------------|-----------|-----------|-----------|
| | APV formula | MoMi adjust | Miles Ezzell | MoMi | TCF | WACC |
| Residual Value | 38,201.45 | 38,201.45 | 30,664.13 | 31,159.75 | 32,585.23 | 32,853.04 |
| Firm Value with debt | 38,491.14 | 38,701.45 | 39,275.32 | 39,807.30 | 41,460.79 | 41,643.10 |
| Net Firm Value | 34,275.48 | 34,485.80 | 35,059.66 | 35,591.64 | 37,245.14 | 37,427.44 |

4.3 Дансны үнэ цэнэд суурилсан санхүүжилт

Дансны үнэ цэнэд суурилсан санхүүжилтийн үед мөнгөн гүйлгээнээс хөрөнгө оруулалтад тогтмол 0.2 хувийг зарцуулж байна гэж тооцсон ба элэгдэл хорогдлын хугацааг 5 жилээр авч мөн аккуралсд хөрөнгө оруулалт хийхгүй гэж үзэж тооцоолол хийсэн.

| | Financing Based on Book Value | | | | |
|----------------------|-------------------------------|-------------|--------------|----------------|--------------|
| | Full Distribution | Replacement | MoMi formula | IP Based on CF | Adapted Momi |
| Firm Value with debt | 38,362.92 | 38,371.23 | 38,674.11 | 40,103.01 | 38,702.44 |
| Net Firm Value | 34,147.26 | 34,155.57 | 34,458.45 | 35,887.35 | 34,486.78 |

5. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хөрөнгийн зах зээл дээрх 14 компанийн хувьцаанд, 1 компанийн хөрөнгийн үнэлгээнд дүн шинжилгээ хийлээ. Судалгааны үр дүнд 14 компаниас үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 6 компани бүгд зах зээл дээрх үнэ цэнээ өсгөж чадахгүй байна. Энэ 6 компанийн анхдагч хөрөнгийн үнэ үйлдвэрлэлийн секторын энэ их хэмжээний хөөсрөл, тодорхойгүй байдал нь хөрөнгийн зах зээл дээрх арилжаанд нөлөөлөх, зогсонги байдалд хүрэх, хөрөнгө оруулагчдын итгэл буурах зэрэг эрсдэлд оруулж болзошгүй юм. Энэ асуудлын шалтгаан нь анхдагч зах зээлд гарах үеийн үнэлгээг хэт өндөр тогтоох секторын эрсдэлийг бага тооцох зэрэгээс хамаарсан гэж үзэж байна.

“Түмэншувуут” ХК-ийн хөрөнгийн үнэлгээнд ашигласан “Miles–Ezzell болон Modigliani–Miller”-ийн засварлалтын үр дүн дараах байдалтай гарсан. Анхдагч зах зээлд гарах үеийн компанийн үнэлгээ 45.7 тэрбум

төгрөг байсан ба өр төлбөрөө хасаж тооцсон цэвэр үнэ цэнэ нь 40.1 тэрбум төгрөг юм. Харин 10 дугаар сарын 31-ний байдлаар зах зээл дээрх үнэ цэнэ 29.3 тэрбум төгрөг байна. Засварлалтын үр дүнд үнэ цэнэ санхүүжилтийн хэлбэрээс хамааран 34.1 – 37.4 тэрбум төгрөг байсан ба 25–55 хувь хүртэл бууруулах боломжтой гэж гарлаа. Уг компанийн 25 хувь нь 10 тэрбумын үнэлгээтэй анх гарсан ба одоогоор 26.1 хувь буюу 10.7 тэрбум төгрөгийн үнэ цэнээ алдаад байна.

Мөн энэ асуудлын хүрээнд аудитын хяналт шалгалтыг сайжруулах компани зах зээл дээр гармагц түүнээс хойших санхүүжилтийн бодлогын биелэлтэд судалгаа хийх зэргээр энэ асуудлыг анхааралдаа авч ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Lutz Kruschwitz and Andreas Löffler /2006/ *Discounted cash flow: A Theory of Valuation Firms*. Wiley Finance Series. www.wiley.com/Finance

Brealey, R.A, Franklin Allen and Myers, S.C. /2014/ *Principles of Corporate Finance*, 12th ed. McGraw Hill New York.

Bodie, Z. Kane & Marcus, A.J /2012/ *Essentials of Investments*, 9th ed. McGraw–Hill Irwin, New York.

Hamilton, J.D. /1994/ *Time Series Analysis*. Princeton University Press, Princeton, N.J.

Löffler, A. /2000/ *Tax Shields in an LBO*. Discussion paper, Freie Universität Berlin. Available at www.ssrn.com/paperID217148/.

Löffler, A. /2002/ *WACC Is Not An Expected Return Of The Levered Firm*. Discussion paper, Universität Hannover. Available at www.ssrn.com/paperID340300/.

Санхүүгийн Зохицуулах Хороо www.frc.mn

Монголын Хөрөнгийн Бирж www.mse.mn



“АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦОО ҮЦК” ХХК



Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 147 дугаар тогтоол, үнэт цаас, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд Сангийн сайдын 2015 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 280 дугаар тушаал, Сангийн сайдын 2016 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 138, 139 дүгээр тушаалын дагуу “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-ийг өөрчлөн зохион байгуулж, арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх чиг үүрэг бүхий зуун хувь төрийн өмчит “Арилжааны төлбөр тооцоо” ТӨХХК-ийг үүсгэн байгуулсан. 2017 онд Санхүүгийн зохицуулах хорооны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 73 тоот тогтоолоор үнэт цаасны арилжааны тооцооны болон төлбөр үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан.

Тус компани нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /МХБ/ дээр хийгдэж байгаа үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог Т+0 өдөр, үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог Т+1 өдөрт тулгуурлан гүйцэтгэж байна. Мөн Засгийн газрын үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрийн харилцагчидтай хийх төлбөр тооцоог хариуцан ажиллаж байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Үнэт цаасны клирингийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн шуурхай, эрсдэлгүй, найдвартай гүйцэтгэж, хөрөнгийн зах зээлийн хөгжлийн тогтвортой өсөлтийг дэмжинэ.

АЛСЫН ХАРАА



IOSCO-ийн стандартыг хангасан ССР /Central Counterparty/ клирингийн байгууллага болно.

“Арилжааны төлбөр тооцоо ҮЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Эрдэнэгэрэл

2018 онд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 4.0 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлж, банк хоорондын их дүнтэй гүйлгээний RTGS системийн 2 дугаар хувилбарт шилжиж, ACG /Asia Pacific Central Securities Depository Group/ олон улсын байгууллагын гишүүнээр элсэв. 2019 онд RTGS II-ACH+ Төлбөр тооцооны системийн шинэчлэл хийгдэж, төлбөр тооцооны системийн шинэчлэх ажлыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг гол зорилтоо болгон ажилласан.

2019 онд үнэт цаасны анхдагч зах зээлд Засгийн газрын бонд, компанийн бондын арилжаа хийгдээгүй бөгөөд 4 компанийн IPO хийгдэж 42.5 тэрбум төгрөгийн төлбөр, тооцоог хийж гүйцэтгэлээ. Мөн тус онд үнэт цаасны хоёрдогч зах зээлд МХБ-ээр нийт 187 удаагийн арилжаа явагдсан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжааны төлбөр тооцоог Т+1 хугацаанд цэвэршүүлэн 15.4 тэрбум төгрөгийн төлбөрийг хийж гүйцэтгэсэн.

“Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т санхүүгийн үйлчилгээг олон улсын стандартад

нийцүүлэн хөгжүүлэхээр заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /СЗХ/ болон Сангийн яам /СЯ/-наас хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудтай хамтран клирингийн шинэ үйлчилгээ буюу төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт аргачлалыг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхээр бэлтгэл ажлууд хангагдаж байна.

Энэ үйлчилгээ нь хөрөнгө оруулагч мөнгөн хөрөнгөө урьдчилан бүрэн хэмжээгээр байршуулалгүйгээр үнэт цаас худалдан авах хэлцэл хийж, үнэт цаасны төлбөрийг 2 хоногийн дараа төлөх шинэ үйлчилгээ бөгөөд гадаад дотоодын хөрөнгө оруулагч үнэт цаасны арилжаанд ижил нөхцөлөөр оролцох, бага хөрөнгөөр их үнийн дүнтэй арилжаа хийх, үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах зэрэг хөрөнгө оруулагчдад хүргэх санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй чухал ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Түүнчлэн хөрөнгийн зах зээлийн үнэ ханш, шинжилгээ судалгааны мэдээллийг глобал түвшинд хүргэдэг Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE индексийн Watch list /Ажиглалтын жагсаалт/-д Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн мэдээлэл орох боломж бүрдэнэ.

Үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгийг бүрэн байршуулалгүй хэлцэл хийснээр тухайн хэлцлийн төлбөр тооцоо хийгдэж дуусах хүртэл 2 хоногийн хугацаанд төлбөр бүрэн төлөгдөхдөхгүй байх эрсдэл үүсэх бөгөөд СЗХ-ноос олгосон үнэт цаасны клирингийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд “Арилжааны төлбөр тооцоо” ХХК клирингийн үйлчилгээ үзүүлж, энэхүү эрсдэлийг өөрийн гишүүн компаниудтай хамтран удирдан, эцсийн хариуцлагыг хүлээх юм.

Төлбөрийн эрсдэл /дефолт/-ийг олон улсын стандартын дагуу санхүүгийн болон мэргэжлийн өндөр чадавх бүхий клирингийн гишүүн элсүүлэх, төлбөрийн тодорхой хувиар тооцон урьдчилгаа буюу маржин барьцаа авах, эрсдэл /дефолт/ үүссэн үед ашиглах дундын сан байгуулах зэрэг арга хэрэгслүүдээр дамжуулан удирдах бөгөөд одоогоор “Үнэт цаасны клирингийн журам” батлагдан энэхүү журмын зохицуулалтын хүрээнд клирингийн гишүүн элсүүлэх, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, систем программ хангамжийг хөгжүүлэх, турших ажлууд хийгдэж байна.

Олон улсын стандартад нийцсэн санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгыг амжилттай хэрэгжүүлэх үйлсэд зохицуулалтын болон зохицуулагч байгууллагууд хамтран зүтгэж үр үр дүнд хүрнэ гэдэгт итгэлтэй байна.



ӨРГӨН ДУРАН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН БНЭУ-ЫН ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингхийг хүлээн авч уулзан, хамтран ажиллах талаар ярилцав.



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд М.П.Сингх, Энэтхэг улс Монгол Улсын стратегийн түнш улсын хувьд хоёр улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд хамтран ажиллах өргөн боломж бийг онцлоод, Энэтхэгийн ЭСЯ-ны зүгээс Хорооны ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, БНЭУ-д урт, богино хугацааны мэргэжлийн сургалтуудад хамруулж, цаашид хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлд анхаарч ажиллана гэлээ.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО АНУ-ЫН ЭСЯ-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАНА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан АНУ-ын ЭСЯ-ны Нэгдүгээр нарийн бичгийн дарга Бенжамин Рой, АНУ-ын сангийн яамны Техникийн туслалцааны албаны суурин төлөөлөгч Н.Клайд Родс нарыг хүлээн авч уулзав.



Энэ үеэр Хорооны зүгээс Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахын тулд хийж буй ажлыг танилцуулж, СЗХ-ны зохицуулалтад шинээр нэмэгдэж орсон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрсдэлийг үнэлэх, зохицуулалтыг сайжруулах чиглэлээр санал солилцож, хамтын ажиллагааны боломжуудын талаар ярилцлаа.

ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ ХӨГЖЛИЙН БАНКНЫ СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧТЭЙ УУЛЗАВ

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Европын сэргээн босголт хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгч Ирина Кравченког хүлээн авч уулзав.



Энэ үеэр хоёр тал хамтран хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийнхээ талаар ярилцаж, 2020 онд болон цаашид хамтран ажиллах чиглэл, боломжийн талаар санал солилцлоо.

Уулзалтад Хорооны Ажлын албаны дарга Т.Жамбаажамц, Гадаад харилцаа хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар, Банк бус санхүүгийн байгууллагын газрын дарга Б.Итгэлсүрэн нар оролцов.

ХОРООНЫ ДАРГА Д.БАЯРСАЙХАН ИБУИНВУ-ЫН ЭЛЧИН САЙДЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс /ИБУИНВУ/-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Филип Малонг хүлээн авч уулзан хамтран ажиллах талаар ярилцлаа.



Уулзалтад Хорооны дэд дарга Т.Цэрэнбадрал, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга В.Энхбаатар, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын дарга Б.Долгорсүрэн нар оролцож Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулахын тулд хийж буй ажил, Олон улсын хамтын ажиллагааны бүлэг /ICRG/-тэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрхэн биелүүлж байгаа талаар танилцуулав.

Энэ үеэр Элчин сайд Филип Малон, Хороо богино хугацаанд дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байгааг онцлон дурдаад Олон улсын хамтын ажиллагааны бүлэгтэй тохиролцсон эрчимжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг биелүүлэхтэй холбоотойгоор СЗХ-г чадавхжуулах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх боломжтой гэв.

САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ

» Эхлэл 1-р нүүрт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛБАНК, САНГИЙН ЯАМ, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ ХАМТРАН ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА

Хөтөлбөрийн үндэслэл

Санхүүгийн тогтвортой байдал нь иргэдээс санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг багасгах гэсэн хоорондоо нягт уялдаа бүхий зорилтуудыг хэрхэн хангаж байгаагаар тодорхойлогддог. Санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх асуудал ач холбогдол өндөртэй хэвээр байна. Зах зээл өргөжин тэлж, дэвшилтэт технологи олноор нэвтэрч, банк, санхүүгийн салбар хөгжин, санхүүгийн зуучлал гүнзгийрэхийн хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл төрөлжин олширсоор байна. Манай улсад иргэн, өрх гэрийн түвшинд санхүүгийн суурь мэдлэг хангалттай бус байгаагаас санхүүгийн буруу шийдвэр гаргаж эрсдэлд орох, энэ нь санхүүгийн салбарт сөрөг нөлөөлөл үүсгэх эрсдэлтэй байгаа нь энэхүү хөтөлбөрийг өргөн цар хүрээтэй, үр өгөөжтэй хэрэгжүүлэх шаардлагыг зүй ёсоор бий болгож байгаа юм.

Хөтөлбөрийн тухай

Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд **“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”**-ийг боловсруулсныг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл 2015 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр дэмжин, улмаар 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан тушаалаар баталсан нь энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх эхлэл тавигдсан. Хөтөлбөрийг дараах дөрвөн тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
3. Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр санхүүгийн мэдлэг олгох.


Хөтөлбөрийн ач холбогдол

Иргэдийн санхүүгийн мэдлэг сайжрах нь эдийн засгийн бодит өсөлт болон ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчид, санхүүгийн үйлчилгээний салбар, засгийн газар, төв банк, бусад санхүүгийн зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, боловсрол олгогчид, ажил олгогч, ажиллагсад болон сайн дурын байгууллагууд зэрэг олон оролцогч талуудад ашиг тусаа өгөх юм.

Иргэдийн санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр гарах үр дүн:

- Санхүүгийн бүтээгдэхүүний худалдан авалт нэмэгдэнэ;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох чадвартай болно;
- Санхүүгийн залилан, мэхлэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нэмэгдэж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна;
- Хувь хүний ажлын бүтээмж нэмэгдэнэ;
- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө;
- Ядуурал, гэмт хэрэг буурна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагууд:



Хөтөлбөрийн цахим хуудас:

<https://sankhuugiinbolovsrol.mn/>

<http://www.frc.mn/as/yourfinance>

<https://www.ncle.mn/>

<https://www.mongolbank.mn/financialliteracy.aspx>

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/-аас Компанийн засаглалын зарчмуудыг анх удаа 1999 онд баталсан бөгөөд үүнээс хойш эдгээр зарчмууд нь бодлого тодорхойлогчид, хөрөнгө оруулагчид, компани болон бусад оролцогч талуудын хувьд олон улсын жишиг баримт болсоор иржээ.

Улмаар 2004 онд зарчмуудыг дахин хэлэлцэж баталсан бөгөөд эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн хурдацтай уялдуулан өмнөх туршлагаудыг тусган уг зарчмуудад нэмэлт, өөрчлөлт оруулж 2015 онд дахин шинэчлэн батлаад байна.

Компанийн засаглалын зорилго нь урт хугацааны хөрөнгө оруулалт, санхүүгийн тогтвортой байдал, бизнесийн бүрэн бүтэн байдлыг хөхүүлэн дэмжихэд шаардлагатай итгэлцэл, ил тод байдал, хариуцлагын орчинг бүрдүүлэх, эдгээрээр дамжуулан эдийн засгийн өсөлт, нийгмийн хариуцлага, шударга, ил тод зах зээлийг дэмжих явдал юм.

Компанийн засаглалын зарчмууд нь 6 бүлгээс бүрдэнэ. Үүнд:

1. Компанийн засаглалын үр ашиг бүхий тогтолцооны үндсийг бүрдүүлэх

Компанийн засаглалын үндсэн тогтолцоо нь эдийн засагт үзүүлэх нөлөө, зах зээлийн бүрэн бүтэн байдлыг дэмжсэн үр ашигтай, шударга байх ёстой. Энэ нь хууль дүрэмтэй нийцэж, үр дүнтэй хяналт шалгалт хийх, хэрэгжүүлэх боломжийг хангасан байна. Хянах, зохицуулах, хууль сахиулах байгууллагууд нь өөрийн эрх үүргээ шударгаар мэргэжлийн түвшинд хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх мэдэл, хүчин чадал нөөцөөр хангагдсан байх ёстой байдаг. Мөн тэдний шийдвэр нь цагаа олсон, ил тод, ойлгомжтой буюу тодорхой, мөн нийтийн эрх ашигт нийцсэн байх ёстой бөгөөд олон улсын хамтын ажиллагааг байнга сайжруулж, хөгжүүлж байх нь зүйтэй.

2. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, бүх хувьцаа эзэмшигчдэд адил, тэгш хандах ба өмчлөлийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх

Компанийн засаглалын тогтолцоо нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах болон эрхээ эдлэхэд нь туслалцаа үзүүлээд зогсохгүй,

бүх хувьцаа эзэмшигчид ялангуяа цөөнх хувьцаа эзэмшигчдийг ялгаварлахгүй адил тэгш хандах нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн хувьцаа эзэмшигчид зөрчигдсөн эрхээ үр дүнтэйгээр нөхөн сэргээж авах боломжоор хангагдсан байх ёстой.

3. Мэргэжлийн хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл болон бусад зуучлагчдын үйл ажиллагаа

Компанийн засаглалын тогтолцоо нь хөрөнгө оруулалтын гинжин хэлхээний туршид зохистой хөшүүрэг үзүүлж, үнэт цаасны зах зээлийг компанийн сайн засаглалд хувь нэмэр оруулахуйц байдлаар үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

Бодит байдал дээр компани болон хөрөнгө оруулагч буюу эцсийн өмчлөгчийн дунд олон төрлийн зуучлагч байдаг ба хөрөнгө оруулалтын үйл явц нь удаан, төвөгтэй байдаг.

Мэргэжлийн хөрөнгө оруулагч буюу хамтын хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, даатгалын компани, хедж сан зэргийн хувьцааны хөрөнгө оруулалтын хувь хэмжээ нь маш ихээр нэмэгдэж байгаа бөгөөд үүнийг мэргэжлийн хөрөнгийн менежерүүд удирдаж байдаг.

Мөн хөрөнгө оруулагчдын шийдвэрт нөлөөлөх дүн шинжилгээ, зөвлөгөө өгдөг итгэмжлэгдсэн зөвлөх, шинжээч, брокер, рейтингийн буюу үнэлгээний байгууллага нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж үнэн зөв, найдвартай мэдээллийг нээлттэй хүргэж байх шаардлагатай болдог.

4. Компанийн засаглалд оролцогч талуудын үүрэг

Компанийн засаглалын тогтолцоо нь оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, ажилчид, зээлдүүлэгчид, үйлчлүүлэгчид, нийлүүлэгчид болон бусад оролцогч талуудын эрхийг хууль тогтоомж, хамтын гэрээ хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого, мэдээллээр цаг алдалгүй хангаж оролцогч талуудын хоорондын идэвхтэй хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ. Компанид болж буй хууль бус эсвэл ёс бус үйлдлийн талаар холбогдох газарт чөлөөтэй мэдээлэх бололцоогоор хангагдсан байх ёстой ба ингэснээр тэднийг шахан хавчих байдлаар

эрхийг нь зөрчиж болохгүй.

5. Мэдээллийн нээлттэй, ил тод байдал

Компанийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, өмчлөл, болон засаглалтай холбоотой бүхий л мэдээллүүд нь хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргах чухал мэдээллүүд байдаг тул эдгээр мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, нийтэд нээлттэй байлгах боломжоор хангах шаардлагатай. Мэдээлэл ил тод байснаар компаниуд хөрөнгө татах болон зах зээл дээр илүү итгэлцлийг бий болгох боломжтой болдог. Мөн санхүүгийн тайланг хөндлөнгийн, мэргэжлийн аудитын байгууллагаар баталгаажуулж байх ёстой.

6. ТУЗ-ийн үүрэг хариуцлага

Компанийн засаглал нь ТУЗ-ийн зүгээс компанийн үйл ажиллагааг стратеги удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд байнгын зохистой хяналтыг тавьж, хараат бус, бие даасан шийдвэр гаргах, компани болон хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээх, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах боломжийг бий болгодог.

КОМПЛАЙНСЫН ТОГТОЛЦООНЫ ТАЛААР

Комплайнс гэдэг нь байгууллагын дотооддоо мөрдөж буй бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, үйл ажиллагааны горим болон практик дадал зэрэгт тавигддаг шаардлагуудыг бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн нийгмийн үнэт зүйлстэй уялдан зохицуулах засаглалын хэрэгсэл юм.

Энэхүү хэрэгслийг амьдралд нутагшуулах гэдэгт тухайн байгууллагыг төлөөлж буй ажилтан өөрийн тодорхой үйл ажиллагаагаа комплайнсын стандартуудад захирагдан үйлдэж байх нөхцөлийг бүрдүүлэх гэж ойлгож болно.

Манай орны хувьдаж ахуйн нэгжүүд өөрсдийн үйл ажиллагааг сайжруулах үүднээс сайн засаглал, нийгмийн хариуцлага, хүний нөөц болон эрсдэлийн удирдлага, дотоод хяналт зэрэг засаглалын олон хэрэгслүүдийг нэвтрүүлж эхлээд удаагүй бөгөөд комплайнс хэмээх тогтолцоо хөгжлийнхөө эхэн үедээ байна. Харин хөгжингүй орнуудын хувьд энэхүү тогтолцооны олон хэлбэрүүд бизнесийн бүх салбаруудад нэгэнт хэвшээд эхэлжээ.

Комплайнсыг хэрэгжүүлнэ гэдэгт эрх зүйн хэм хэмжээ ба байгууллагын дотоод комплайнс хяналтын стандартуудыг мөрдөх үйл явц, хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчлүүдийг зохих хяналтын бүтцэд мэдэгдэх бие даасан, байнгын ажиллагаатай удирдлагын тогтолцоог хамруулан ойлгож болно.

Комплайнсын тогтолцоонд дараах эрсдэлүүд хамаарч байна. Үүнд:

- Зохицуулалтын нөхцөл, шаардлагын хүрээнд учирч буй зөрчил;
- Санхүүгийн хууль бус үйлдэл;
- Албан тушаалаа урвуулан ашиглах, эсхүл авилгын үйлдэл;
- Албан хаагчдын мэргэжлийн бус үйлдэл;
- Гадна талаас учирч болох хууль бус үйлдэл;
- Бизнесийн нэр хүнд унах, санхүүгийн чадамжгүй болох эрсдэл.

Дээр дурдсан эрсдэлүүдээс дараах хор хохирол учирч болно. Үүнд:

- Материаллаг;
- Цаг хугацааны;
- Үнийн дүн бүхий;
- Оюуны өмчийн;
- Мэдээллийн;
- Хөдөлмөрийн хүчний;
- Бусад хохирол /хүний амь нас, эрүүл мэнд, байгаль, экологи, байгууллагын нэр хүндэд учрах хор хохирол гэх мэт/.

Зарим байгууллагууд дотоод хяналт болон комплайнсын бизнес эрхлэхэд төдийлөн ач холбогдолгүй гэж үзээд тэдгээрт цаг хугацаа, хөрөнгө оруулах сонирхолгүй байдаг бол зарим компанийн жишээн дээр чанартай комплайнс хяналт нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлдгийг практик дээр харуулсаар байна. Энэ нь үйлчлүүлэгчдийн эерэг хандлага, зан төлөв, хөрөнгө оруулагчдын сонирхол, хувьцаа эзэмшигчдийн компанид итгэх итгэл, нийгмийн хандлага зэргээр илэрхийлэгддэг.

Тухайлбал, олон улсын хөрөнгийн зах зээлд үнэт цаасаа санал болгож буй компанийн хувьд тэрээр өөрийн комплайнс тогтолцоотой байх нь тухайн орны зохицуулагч байгууллага болон мэргэжлийн институционал хөрөнгө оруулагчдын зүгээс нааштай эерэг үнэлгээ өгөх суурь нь болдог.

Мөн үр дүн бүхий комплайнс хяналтын тогтолцоо нь хөрөнгө оруулах сонирхол,

санхүүгийн болоод үйл ажиллагааны найдвартай байдлын түвшинг дээшлүүлдэг байна. Нөгөө талаас АНУ /Foreign Corrupt Practices Act 1977/, ИБУИВУ /UK Bribery Act 2010/ зэрэг орнуудын хууль эрх зүйн орчны хүрээнд гадаадын компани өөртөө үр дүн бүхий комплайнсын нэгжтэй байхыг чухалчлан шаарддаг.

Одоогоор манай улсын хувьд хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын оролцогчид болон гадаадын зах зээлд түшиглэн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь комплайнсын хяналтыг эхний ээлжинд нэвтрүүлэх зорилготой бүлгүүд болоод байна.

Нөгөө талаас комплайнсын хяналтыг нэвтрүүлэх нь тухайн байгууллагын хэмжээ, үйл ажиллагааны далайцаас огт хамааралгүй юм. Учир нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон авилгын эсрэг эрх зүйн орчин болон комплайнсын стандартуудыг зах зээлд оролцогч бүх талууд мөрдөх үүрэгтэй.

Байгууллагын хийж буй хэлцэл бүрийг комплайнсын хяналтаар шалгаж болох энэ тогтолцоо нь удаан хугацаанд амжилттай явах итгэл найдварыг бизнес эрхлэгчдэд бий болгодог байна.

Харин комплайнсын хяналттай холбоотойгоор дараах эрсдэлүүд бизнесийн байгууллагад үүсэж болно. Үүнд:

- Гүйлгээний данс хаагдах, царцах;
- Төлөвлөгөөт бус газар дээрх хяналт шалгалт хийгдэх;
- Захиргааны арга хэмжээ, торгууль тавигдах;
- Үйл ажиллагаа нь хэсэгчлэн, эсхүл бүрэн зогсох;
- Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл нь түдгэлзэх, цуцлагдах;
- Төлбөрийн чадваргүй болох;
- Нэр хүнд нь унаснаар бусдаас хөрөнгө татах түвшин нь буурах.

Комплайнсын хяналтын чиг үүргийн үндсэн зарчмууд

1. Хараат бус байдал: Энэхүү зарчим нь өөр хоорондоо харилцан нягт уялдаатай 4 комплайнсын хэсгээс бүрддэг байна.

- Комплайнсын хяналтын үйл ажиллагаа нь албан ёсны бие даасан байх;
- Комплайнсын эрсдэлийн удирдлагын уялдааг хангах комплайнсын мэргэжилтэнтэй байх;
- Компанийн ажилтнуудын хооронд

сонирхлын зөрчил үүсгэхгүй байх;

- Комплайнсын хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүү, төсөвтэй байх ба комплайнсын мэргэжилтэн нь байгууллагын бүх нэгжүүдээс шаардлагатай мэдээллийг авах эрх нь нээлттэй байх.

2. Эрх зүйн байдал: Комплайнсын хяналтыг зохицуулж буй норматив, стандартуудыг байгууллагын дотоод дүрэм, журамд тусгах ба дараах нөхцөлүүдийг багтаасан байна.

- Комплайнсын хяналтын зорилго, чиг үүрэг ба комплайнсын мэргэжилтний үүрэг хариуцлага;
- Комплайнсын хяналтын хараат бус байдлыг хангасан нөхцөлүүд;
- Эрсдэлийг хянах чиглэлээр комплайнсын хяналтын нэгж байгууллагын бусад нэгжүүд, дотоод хяналтын нэгжтэй хамтран ажиллах аргачлал;
- Комплайнсын мэргэжилтний шаардлагатай гэж үзсэн мэдээллийг авах эрх, мөн бусад ажилтнуудын түүнд мэдээлэл өгөх үүрэг, хариуцлага;
- Комплайнсын норматив, стандартыг зөрчсөнтэй холбоотойгоор дотоод шалгалт хэрэгжүүлэх эрх;
- Комплайнсын мэргэжилтний компанийн удирдлага /ТУЗ, ТУЗ-ийн хороод, гүйцэтгэх удирдлага/-д мэдээлэл өгөх, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх;
- Комплайнсын чиглэлээр компанийн эрх бүхий этгээдийн тайлагналд хяналт тавих эрх;
- ТУЗ болон түүний хороодтой шууд харьцах эрх.

3. Комплайнсын мэргэжилтний тайлагнал: Компанийн салбар, нэгжид хамаарах комплайнсын мэргэжилтэн өөрийн шууд удирдлагадаа үйл ажиллагаагаа тайлагнах бөгөөд комплайнсын чиглэлээр компанийн комплайнсын хяналтын удирдах ажилтанд мөн тайлагнана.

4. Сонирхлын зөрчлийг арилгах: Комплайнсын мэргэжилтний хараат бус байдал нь түүний байгууллагад ажиллаж буй ердийн албан тушаалаар хүлээсэн үүрэг, хариуцлагатай сонирхлын зөрчил үүсгэснээр алдагдаж болно. Мэдээж комплайнсын ажилтан нь зөвхөн комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх нь зохистой боловч ихэвчлэн жижиг компаниудын хувьд энэ нь боломжгүй тул давхар чиг үүрэг хүлээдэг. Энэ нөхцөлд сонирхлын зөрчлийг үүсгэж болох нөхцөлийг арилгах нь маш чухал. Учир

нь комплайнсын хяналтыг хэрэгжүүлж байгаа нэгж түүний үйл ажиллагааны үр дүнгээс комплайнсын ажилтны шагнал, урамшуулал шууд хамаарах боломжтой.

5. Дотоод мэдээллийн нээлттэй байдал: Комплайнсын хяналтын алба нь өөрийн санаачлагын дагуу байгууллагын бүх нэгжийн албан хаагчидтай хамтран ажиллаж, комплайнсын чиглэлээр дурын мэдээллийг авах эрхтэй.

6. Нөөц: Комплайнсын хяналтын үйл ажиллагааны нөөц нь зохих хэмжээнд хангагдсан байх шаардлагатай. Комплайнсын хяналтын үйл ажиллагааны нэг чухал нөөц бол мэргэшсэн, туршлагатай хүний нөөц юм. Мэргэжилтнүүд нь байгууллагын зүгээс

хууль тогтоомж, эрх зүйн акт, нормативыг мөрдөх, тэдгээрийн үр нөлөө, ач холбогдлын талаар мэргэжлийн түвшинд мэлэгтэй байна. Хяналтын арга барил, хууль тогтоомжийн шинэчлэл, өөрчлөлт зэргийг сургалт, дадлагын тусламжтайгаар хэрэгжүүлнэ.

7. Зохицуулагч болон хяналтын байгууллагатай хамтран ажиллах: Комплайнсын хяналтын ажилтнууд хяналтын байгууллагуудтай харилцан үр дүнтэйгээр хамтран ажиллах явдал маш чухал. Энэ тал дээр дараах хүндрэлүүд үүсэж болно. Үүнд:

- Хяналтын байгууллагаас шаардсан баримт, тайлан мэдээг бүрэн хэмжээгээр боловсруулан хүргүүлэх нь хугацаа шаардсан үйл явц ба хэрэв үүнийг цаг

хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд асуудал үүснэ;


- Маргаантай асуудлаар хамтарсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах шаардлагатай ба энэ нь харилцааны чадвар, туршлага, зарим тохиолдолд нэмэлт нөөцийн хэрэгцээг шаарддаг;
- Хяналтын байгууллагаас зөрчил илрүүлсэн тохиолдолд нөхцөл байдлыг дүгнэж шийдвэр гаргах үр чадвар шаардагддаг. Ийм тохиолдолд хяналтын байгууллагатай хамтран ажиллах нь үйл ажиллагаагаа хэвийн үр дүнтэй явуулах суурь нь болдог байна.

ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2019 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 2,693.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 181.3 тэрбум төгрөг буюу 7.2 хувиар өссөн үзүүлэлт юм. Тайлант үед нийт 133.7 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдэж хөрвөх чадвар 5.0 хувь болов. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 3.4 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадвар




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг тайлбарладаг бас нэгэн чухал үзүүлэлт нь хувьцааны индекс байдаг. Манай улсын хувьд “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас хамгийн өндөр үнэлгээтэй 20 компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан тооцдог ТОП-20 индекс, үнэт цаасны бүртгэлийн I ба II ангилалд багтах компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSE A болон MSE B индексүүдийг тооцож байна.

Тайлант үед ТОП-20 индекс өмнөх онтой харьцуулахад 1844.9 нэгжээр буюу 8.6 хувиар буурч 19,621.9 нэгж болсон бөгөөд индексийн дээд үзүүлэлт 21,888.2 нэгж, доод үзүүлэлт 17,922.8 нэгж, дундаж үзүүлэлт 19,984.1 нэгж байна.


ТОП-20 индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2019 оны байдлаар 143.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн. Нийт арилжааны үнийн дүнг бүтцээр нь авч үзвэл хувьцааны арилжаа 93.1 хувь, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа 6.7 хувь, компанийн өрийн бичгийн хоёрдогч зах зээлийн арилжаа 0.1 хувийг тус тус бүрдүүлж байна.

Нийт арилжааны бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Хөдөө аж ахуй, түүхий эдийн зах зээлд арилжаа эрхлэх 1 байгууллага, түүхий эдийн 13 брокер үйл ажиллагаа явуулж байна.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК 2019 онд нийт 705.1 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн. Нийт арилжааны дүнгийн 91.4 хувийг ямааны ноолуур, 5.7 хувийг завод ноос, 2.0 хувийг хонины ноос, 0.6 хувийг адууны шир, 0.2 хувийг тэмээний ноос, 0.1 хувийг тосны ургамал тус тус эзэлж байна.

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2015 оноос 2019 оны жилийн эцэст банк бус санхүүгийн байгууллагын тоо 1.2 дахин нэмэгдэж 538-д, харилцагчдын тоо 6.4 дахин өсөж 2.9 сая болжээ.


Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо болон харилцагчдын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллагын нийт актив 623.2 тэрбум төгрөгөөс 1.7 их наяд төгрөгт хүрч 2.8 дахин, нийт зээл 391.2 тэрбум төгрөгөөс 1.2 их наяд төгрөг болж 3.2 дахин өссөн дүнтэй байна.

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгө болон нийт зээлийн үлдэгдлийн дүн



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2019 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нийт үлдэгдэл өмнөх оноос 41.9 хувиар өсөж, 1.2 их наяд төгрөгт хүрсний 98.2 хувийг төгрөгийн, 1.8 хувийг валютын зээл эзэлж байгаа бол, 87.0 хувийг хэвийн зээл, 4.5 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.5 хувийг чанаргүй зээл тус тус эзэлж байна. 2018 онд салбарын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 9.5 байсан бол тайлант онд уг үзүүлэлт 1.0 нэгжээр буурч, зээлийн чанар сайжирсан байна.


Мөн салбарын зээлийн нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн үйлчилгээний хүртээмж сайжирсан бөгөөд салбарын зээлдэгчдийн тоо өмнөх оноос 1.8 дахин нэмэгдэж 419.9 мянгад, харин нийт харилцагчдын тоо 2.9 саяд хүрчээ. Зээлийн үйлчилгээний хүртээмжийн уг өндөр өсөлт нь зээлийн нийлүүлэлтээс гадна технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлсэнтэй холбоотой юм. Харин зээлийн бүтээгдэхүүний үнэ болох сарын жигнэсэн дундаж хүүгийн түвшин оны эцсийн байдлаар 3.0 хувьтай байгаа бөгөөд хүүгийн түвшин өмнөх оноос 0.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 365.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 33.9 тэрбум төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн ба нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл ердийн даатгалын компаниудын хөрөнгө 76.8 хувь, давхар даатгалын компанийн хөрөнгө 20.6 хувь,

урт хугацааны даатгалын компанийн хөрөнгө 2.5 хувийг тус тус эзэлж байна.


Даатгалын болон давхар даатгалын компаниудын нийт хөрөнгө / тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниуд 2019 оны байдлаар нийт 198.7 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 98.3 хувь буюу 195.3 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.6 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.1 хувь буюу 2.1 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани тус тус төвлөрүүлсэн байна. Тайлант хугацааны даатгалын нийт хураамжийн орлогыг өмнөх онтой харьцуулахад 20 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд хураамжийн нийт орлогын сүүлийн 5 жилийн дундаж өсөлт 13.3 хувьтай байна.


Даатгалын хураамжийн нийт орлого, давхар даатгалын хураамж / тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд ердийн даатгалын салбарын хэмжээнд нийт хохирлын харьцаа 52.8 хувь байна. Үүнд давхар даатгалд төлсөн хураамж болон давхар даатгагчаас төлсөн нөхөн төлбөрийг оруулж тооцсон болно. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 43.4 хувь байна.


Хохирлын харьцаа /хувиар/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын компаниудын нөөц сангийн хэмжээ тайлант хугацаанд 165.6 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 13.4 хувиар өссөн байна.

Нөөц сан /тэрбум төгрөгөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2019 оны байдлаар нийт 261 хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 104 ХЗХ төслийн санхүүжилтийн үйлчилгээ, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх, 3 ХЗХ санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх, 2 ХЗХ даатгалын төлөөлөгчөөр ажиллах нэмэлт зөвшөөрлийг тус тус Санхүүгийн Зохицуулах Хорооноос авсан байна.

Тайлант онд хадгаламж, зээлийн хоршоод нийт 222.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй ажилласан ба энэ нь өмнөх оноос 11.2 хувиар өссөн үзүүлэлт юм.

ХЗХ-дын нийт хөрөнгө, өсөлт



ХЗХ-ны салбарын голлох санхүүгийн үзүүлэлтүүдийг 2015 онтой харьцуулан дараах хүснэгтэд харууллаа. Үүнд:

Санхүүгийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

| д/д | Үндсэн үзүүлэлтүүд | 2015 оны IV улирал | 2019 оны IV улирал | Өөрчлөлт | |
|-----|---|--------------------|--------------------|---------------|-------|
| | | | | дүн | хувь |
| 1 | ХЗХ-дын тоо | 253 | 261 | 8 | 3.2 |
| 2 | Гишүүдийн тоо | 39,146 | 70,968 | 31,822 | 81.3 |
| 3 | Нийт хөрөнгө | 97,698,233.8 | 222,616,661.3 | 124,918,427.5 | 127.9 |
| 4 | Нийт зээлийн үлдэгдэл | 73,267,300.9 | 156,687,162.8 | 83,419,861.9 | 113.9 |
| 5 | Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл | 3,466,986.9 | 6,152,055.8 | 2,685,068.9 | 77.4 |
| 6 | Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл | 59,265,286.8 | 155,803,260.3 | 96,537,973.5 | 162.9 |
| 7 | Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл | 10,626,309.9 | 18,014,225.8 | 7,387,915.9 | 69.5 |
| 8 | Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл | 10,575,323.0 | 24,693,258.8 | 14,117,935.8 | 133.5 |
| 9 | Богино хугацаат зээлийн үлдэгдэл | 1,392,225.1 | 3,776,434.5 | 2,384,209.4 | 171.3 |
| 10 | Нийт орлого | 21,752,831.5 | 50,634,318.3 | 28,881,486.8 | 132.8 |
| 11 | Нийт зардал | 18,507,722.2 | 41,466,340.9 | 22,958,618.7 | 124.0 |
| 12 | Тухайн үеийн ашиг, алдагдал | 3,245,109.3 | 9,167,977.4 | 5,922,868.1 | 182.5 |

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Сүүлийн 5 жилийн хугацаанд нийт ХЗХ-ны тоо 3.2 хувиар, гишүүдийн тоо 81.3 хувиар, нийт хөрөнгийн хэмжээ 127.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Олон улсад Covid 19 өвчний эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, нас баралт, халдварыг бууруулах үүднээс маш олон арга хэмжээнүүдийг үе шаттай авч хэрэгжүүлж байгаа ба тэдгээр арга хэмжээнүүдийн товч тоймыг хүргэж байна. Үүнд:

Америкийн Нэгдсэн Улс

- АНУ-ын засаг захиргааны зүгээс тээврийн салбар, жижиг бизнес эрхлэгчид болон олон нийтэд зориулан 1 их наяд ам.долларын урамшууллын мөнгө олгохоор хэлэлцэв.
- Сангийн яамнаас зарим хувь хүн, аж ахуйн нэгжийн татварын төлбөрийг хүү, торгууль ногдуулахгүйгээр хойшлуулж байна.
- Америкийн агаарын тээврийн салбарын Airlines худалдааны групп нь АНУ-ын тээврийн компаниудад буцалтгүй тусламж, зээл хэлбэрээр 50 тэрбум гаруй ам.долларыг олгож байна.
- Ерөнхийлөгч Доналд Трамп улс орны эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд 2 их наяд ам.долларыг дэмжлэг үзүүлэх хуулийн төсөлд гарын үсэг зурлаа. Үүнээс 500 их наяд ам.долларыг компаниудын, 350 их наяд ам.долларыг жижиг бизнесүүдийн өрийн дарамтыг бууруулахад зарцуулах юм.

Бүгд найрамдах Хятад Ард Улс

- Анх Covid 19 илэрсэн улс болох БНХАУ-ын засгийн газар засгийн газрын бонд гаргаснаар 394 тэрбум ам.долларыг дэд бүтцэд зарцуулахаар төлөвлөсөн.
- Банкууд хугацаа хэтэрсэн өрийн нөхцөлийг сулруулах, зээлдэгчийн зээл төлөх хугацааг хойшлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авахаар болсон байна.
- БНХАУ-ын төв банк банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг 79 тэрбум ам.доллараар бууруулснаар хямралд өртсөн компаниудад зээл олгох боломжтой болж байна. Ингэснээр зээлийн хүү буурах боломжтой хэмээн мэдэгдсэн.

Япон улс

- Японы засгийн газраас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулан 4 тэрбум ам.долларыг зарцуулахаар төсөвлөв.
- Засгийн газрын харьяа зээлдүүлэгч байгууллага нь вирусийн улмаас орлого нь буурсан жижиг компаниудад хүүгүй тусламжийн санхүүжилтийг санал болгосон.
- Японы төв банк 100 тэрбум ам.доллараас илүүтэй тэнцэх хэмжээний биржээр арилжаалагдах санг худалдан авсан бөгөөд энэ нь компаниудад олгох санхүүжилтийг тогтвортой байлгахад зарцуулагдах юм.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

- Берлины засгийн газар бизнесүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд зээл олгох, баталгаа гаргах зэрэгт 750 тэрбум еврог төсөвлөв.
- Испанийн засгийн газар 219 тэрбум ам.долларын мөнгөн тусламж үзүүлэхэд бэлэн байгаа бөгөөд үүнээс 100 тэрбум еврог компаниудын зээлийн баталгаанд, 17 тэрбум еврог аж ахуйн нэгжид шууд дэмжлэг болгон өгөх юм.
- Ерөнхий сайд Педро Санчес хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс 83 тэрбум еврогийн дэмжлэг үзүүлэх болно гэж мэдэгджээ.

Их Британи

- Их Британийн засгийн газар 3-р сарын 20-ны өдөр ажилчдад үнийн дүн заагаагүй чек бичиж байгаагаа мэдэгдлээ.
- Засгийн газрын буцалтгүй тусламж нь 2500 фунт стерлинг хүртэлх мөнгөн дүнг хөдөлмөрийн чадвараа түр хугацаанд алдсан ажилтнуудын цалингийн 80 хувийг төлөхөд зарцуулах бөгөөд 6-р сарыг дуустал ямар ч бизнесийн компаниуд НӨАТ төлөхгүй юм. Мөн 30 тэрбум фунт стерлингтэй тэнцэх хэмжээний НӨАТ-аас бизнесийн байгууллагуудыг чөлөөлөө.
- Их Британийн Засгийн газраас 3 дугаар сарын 17-ны өдөр бизнесийн байгууллагуудыг дэмжих зорилгоор 330 тэрбум фунт стерлинг буюу ДНБ-ний 15 орчим хувьтай тэнцэх хэмжээний зээлийг олгохоор болов. Үүнээс жижиглэн худалдаа, амралт сувиллын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд 25,000 фунт стерлинг хүртэлх мөнгөн тусламжийг авах боломжтой.
- Лондонгийн эрх бүхий албан тушаалтнууд 30 тэрбум фунт стерлингтэй тэнцэх хэмжээний мөнгийг яаралтай тусламжийн зардалд зарцуулах болсноо 3-р сарын 11-ний өдөр зарлав. Үүнд Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний 5 тэрбум фунт стерлингийн тусламжийн сан, өөрийгөө тусгаарлах шаардлагатай ажилчдын цалин, 250-аас цөөн ажилчинтай компанид өвчтөний нөхөн олговор олгох зардлыг багтаав.
- Английн төв банк 3 дугаар сарын 19-ний өдөр бодлогын хүүгээ түүхэн дэх хамгийн доод түвшинд буюу 0.1 хувь хүртэл бууруулж мөн нэмэлтээр 230 тэрбум ам.доллартай тэнцэх бондыг худалдан авав.

Франц Улс

- Франц улсын эрх бүхий албан хаагчид бизнес эрхлэгчид болон ажилчдад туслалцаа үзүүлэхэд 45 тэрбум еврог зарцуулна.
- Ерөнхийлөгч Эммануэль Макрон бизнесийн байгууллагуудад хангалттай хэмжээний тусламж үзүүлэх болсноо мэдэгдэв.

Итали Улс

- Итали улсын засгийн газраас ипотекийн зээл төлөлтийг түр хойшлуулах, татвар болон зээл төлөлтийг түр зогсоох, мөн эрүүл мэндийн салбарт нэмэлт орлогыг төвлөрүүлэх, ажилгүйдлийн тэтгэмжийг нэмэгдүүлэх зэргээр ажилчид болон компаниудыг дэмжих зорилгоор 25 тэрбум еврог зарцуулахаар батлав.

Энэтхэг улс

- Энэтхэг улсын засгийн газраас 600 тэрбум рупитэй тэнцэх хэмжээний зээлийг олгохыг банкуудад шаардлага болгов.
- Энэтхэг улсын төв банкнаас зээлийг хүүг бууруулах, зээл олголтыг нэмэгдүүлэх зорилгоор урт хугацаат репо арилжааг хийх болсноо зарлав.

Канад улс

- Канад улсын засгийн газраас 82 тэрбум канад доллартай тэнцэх буцалтгүй тусламжийг үзүүлэхээр төлөвлөснөөс 27 тэрбум канад долларыг иргэн болон аж ахуйн нэгжүүдэд, 55 тэрбум канад долларыг бизнес болон өрхүүдэд дэмжлэг үзүүлэхээр төсөвлөсөн.

- Канадын төв банк өдрийн хүүгээ 50 нэгжээр буулгаж 0.75 хувь хүртэл бууруулав

Австрали улс

- Австрали улсын эрх баригчид жижиг, дунд үйл ажиллагаа эрхлэгчдэд 15 тэрбум Австрали долларын зээлийг нэмэлтээр олгохоо мэдэгдлээ. 2 дугаар сард 17.6 тэрбум австрали долларын зээлийг мөн олгож байсан байна.

- Австралийн төв банк зээлийн хүүг хамгийн бага буюу 0.25 хувь хүртэл буурууллаа.

Олон улсын валютын сан


- Олон улсын валютын сангаас 1 их наяд ам.долларын зээл олгоход бэлэн байгаагаа мэдэгдэв

ОЛОН УЛСЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС

2020 оны 3 дугаар сарын 31-ны өдөр


S&P 500 (^GSPC)

2,626.65 +85.18 (+3.35%)




Nikkei 225 (^N225)

18,917.01 -167.96 (-0.88%)



FTSE 100 (^FTSE)

5,676.26 +112.96 (+2.03%)





Dubai Financial Market General Index DFMGI:IND

1,773.53 -16.07 /-0.90%/





 Засгийн газрын IV байр, Бага тойруу-3 Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160

 +976-51-264444

 press@frc.mn

 www.frc.mn

 Санхүүгийн зохицуулах хороо

 [@FRC_of_Mongolia](https://twitter.com/FRC_of_Mongolia)